



ӨГӨГДЛИЙН “УУРХАЙ”
2006-2011 ОНЫ ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ
ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар
2013

ӨГӨГДЛИЙН “УУРХАЙ”

2006-2011 ОНЫ ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэж бичсэн: Н.Дорждарь

Хянан тохиолдуулсан: Н.Баярсайхан, Д.Цэрэнжав, С.Одхүү

Дэлхийн Банк, ОУИТБС-ын олон талын хандивлагчдын итгэлцлийн сангийн санхүүжилтээр уг судалгааг хийв.

Энэхүү судалгааг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамьян гүний гудамж

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

DDC

622

Ө-69

ISBN 978-99962-56-49-3

Агуулга

Хүснэгт, зургийн жагсаалт	4
Үгийн товчлол, ба нэр томъёоны тайлбар	6
Өмнөх үг	8
1. Оршил	9
2. Дүгнэлт, зөвлөмж	13
3. ОУИТБС-ын тайлан дахь тоо юуг өгүүлнэ вэ?	17
ОУИТБС-ын тайланд хэн хамрагдаж байна вэ?	18
Ямар төрлийн, хэдий хэмжээтэй төлбөр тайлагнагдсан бэ?	20
ОУИТБС-ын тайланг нэгтгэх үйл явц	27
4. Орон нутгийн иргэд ямар мэдээлэл авах боломжтой вэ?	29
5. Хавсралт 1: ОУИТБС-ын өгөгдлийг нэгтгэж, ангилсан байдал ба өгөгдлийн дутагдалтай талууд	33
6. Хавсралт 2: ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн сангаас уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй нутгийн иргэд ямар мэдээлэл авах боломжтой вэ?	39

Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1.	2006-2011 онд ОУИТБС-ын тайланд хамрагдсан компанийн тоо, тайлагнагч талуудаар	18
Хүснэгт 2.	2006-2011 онд ОУИТБС-ын тайланд хамрагдсан компанийн тоо, салбар, тайлагнагч талуудаар	18
Хүснэгт 3.	2006-2011 онд ОУИТБС-д хамрагдсан байдал	19
Хүснэгт 4.	ОУИТБС-ын тайланд нэг удаа хамрагдсан компаниудын тоо, оноор	19
Хүснэгт 5.	Төлбөрийн тойм	20
Хүснэгт 6.	Төлбөрийн ангилал, тайлагнагч талуудаар	21
Хүснэгт 7.	Төлбөрийн зориулалт, тайлагнагч талуудаар	21
Хүснэгт 8.	Төлбөрийн төрөл, тайлагнагч талуудаар	22
Хүснэгт 9.	Засгийн газар, компаниудын тайлан дахь хамгийн их дундаж хэмжээтэй төлбөрийн төрлүүд	24
Хүснэгт 10.	Хамгийн их төлбөр төвлөрүүлэгч компаниуд, Засгийн газрын тайлагнаснаар (сая төгрөг)	24
Хүснэгт 11.	2006-2011 онд хамгийн их төлбөр төвлөрүүлсэн 10 компанийн төлбөрийг бусад компаниудынхтай харьцуулсан байдал, Засгийн газрын тайлагнаснаар	25
Хүснэгт 12.	ОУИТБС-д оролцогч компанийн тоог ОУИТБС-ын нэгтгэлийн тайланд хамрагдсан компанийн тоотой харьцуулсан байдал	27
Хүснэгт 13.	Нэгтгэлд хамрагдсан компанийн тоо, давтамж	27
Хүснэгт 14.	Анхны тайлангийн болон шийдвэрлэгдээгүй зөрүүний дүн	28
Хүснэгт 15.	ОУИТБС-ын 2011 оны тайланд хамрагдсан компаниудын эзэмшдэг лицензийн тоо, төрөл	31
Хүснэгт 16.	ОУИТБС-ын тайланд хамрагдсан компаниудын эзэмшдэг лицензийн талаарх зарим статистик мэдээлэл	31
Хүснэгт 17.	Хамгийн олон аймагт лиценз эзэмшиж буй компаниуд	32
Хүснэгт 18.	Лиценз эзэмшиж буй компанийн тоо, аймгаар	32
Хүснэгт 19.	Баянхонгор аймгийн Галуут суманд лиценз эзэмшиж буй компанийн жагсаалт	40
Хүснэгт 20.	Галуут суманд олгогдсон лиценз, хамрах талбай	40
Хүснэгт 21.	2011 оны ОУИТБС-ын хүрээнд компанийн болон Засгийн газрын тайланд хамрагдсан компаниудын төлбөрийн хэмжээ	41
Хүснэгт 22.	Жамп Голд ХХК-ийн ОУИТБС-ын 2011 оны тайлан	41
Хүснэгт 23.	ОУИТБС болон лицензийн өгөгдлийн санд уул уурхайн компанитай холбоотой нутгийн иргэдэд хамаарах мэдээллийн жагсаалт	42

Зураг 1.	ОҮИТБС-ын тайланд хамрагдсан компаниуд, хариуцлагын хэлбэрээр	19
Зураг 2.	Компани, Засгийн газрын тайланд орсон төлбөрийн харьцуулалт	22
Зураг 3.	Засгийн газрын тайланд тусгагдсан төлбөрийн бүрдэлт, төлбөрийн төрлөөр	23
Зураг 4.	Төлбөрийн төрөл, ОҮИТБС-ын тайланд тусгагдсан байдлаар	23
Зураг 5.	ОҮИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийн ДНБ-д эзлэх хувь	25
Зураг 6.	ОҮИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийн нэгдсэн төсөвт эзлэх хувь	26
Зураг 7.	ОҮИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийн уул уурхайг төсвийн орлогын хэмжээтэй харьцуулсан дүн	26
Зураг 8.	ОҮИТБС-ын 2011 оны тайланд орсон компаниудын олборлож буй ашигт малтмалын төрөл	31

ҮГИЙН ТОВЧЛОЛ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- Аудитор** Компанийн төлсөн төлбөр, Засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэн, компани болон Засгийн газраас гаргасан тайлангийн төлбөр, орлогын дүнд гарсан аливаа зөрүүг тайлбарлах замаар ОУИТБС-ын тайланг нэгтгэн бэлтгэх үүрэг бүхий, санхүүгийн хяналтын туршлагатай бие даасан этгээд буюу зөвлөх байгууллага.
- Компанийн тайлан** ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс баталсан маягтын дагуу олборлох компаниудын жил тутам гаргадаг тайлан. Уг тайланд тухайн компанийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж зэрэг албан ёсны аливаа төлбөр, түүнчлэн хандив, дэмжлэг зэрэг бусад төрлийн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг тусгадаг.
- ОУИТБС** Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага; тухайн улс оронд олон талын оролцоот бүлгийн хяналт дор ОУИТБС-ын тайланг гаргах замаар олборлох салбарын ил тод байдлыг дээшлүүлэх зорилго бүхий олон улсын санаачлага.
- ОУИТБС-ын Үндэсний зөвлөл (Монгол Улс)** Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан, ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах, хянах үүрэг бүхий Засгийн газар, олборлох салбар, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн гурван талт бүлэг. Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг.
- ОУИТБС-ын Ажлын алба (Монгол Улс)** Дэлхийн Банк, Олон талын хандивлагчдын итгэлцлийн сангаас санхүүжиж буй, ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх ажлыг дэмжих, уг санаачлагын бүхий л үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангах, ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий нэгж.
- ОУИТБС-ын Ажлын хэсэг (Монгол Улс)** ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий, гурван талт болон засгийн газар, олборлох салбар, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн бүлэг. Ажлын хэсгийг Ерөнхий сайдын Ахлах зөвлөх тэргүүлдэг.
- ОУИТБС-ын Олон талын оролцоот бүлэг** ОУИТБС-ын хэрэгжилтийг үндэсний түвшинд удирдан зохицуулдаг төр засаг, салбар, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн бүлэг. Монгол Улсын хувьд Үндэсний зөвлөл ба Ажлын хэсэг нь уг бүлгийн үүргийг гүйцэтгэнэ.
- ОУИТБС-ын тайлан** Энэхүү судалгааны тайланд “ОУИТБС-ын тайлан” нэр томъёог хоёр тохиолдолд хэрэглэсэн болно. Нэгд, ОУИТБС-ын тайлан нь компанийн болон Засгийн газрын тайланг нарийвчлан харьцуулж, холбогдох тайлангуудын төлбөр, орлогын хооронд үүссэн аливаа зөрүүний учир шалтгааны тайлбарыг тусгасан, хөндлөнгийн аудитор буюу нэгтгэгчдийн бэлтгэдэг тайлан юм. Хоёрт, ОУИТБС-ын тайлан нь Үндэсний зөвлөлөөс баталсан ОУИТБС-ын тайлангийн маягтуудын дагуу компаниуд, Засгийн газрын зүгээс бэлтгэн гаргасан тайлангууд буюу нэгтгэлийн ажлын өмнөх тайлангууд юм.
- Засгийн газрын тайлан** ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс баталсан тайлангийн тусгай маягтын дагуу Засгийн газраас жил тутам бэлтгэдэг тайлан. Уг тайланд олборлох салбарын компаниудаас Засгийн газрын хүлээн авсан аливаа албан орлогын талаар нарийвчилсан мэдээллийг оруулдаг ба үүнд татвар, төлбөр, хураамж, түүнчлэн хандив, дэмжлэг зэргийг тусгадаг.

- Орон нутгийн төсөв** Монгол Улсын Төсвийн тухай хуулинд тодорхойлсны дагуу ойлгоно; орон нутгийн төсвийн орлогод газар болон ус ашигласны төлбөр, орон нутгийн өмчид ногдох ашиг, ашигт малтмалын нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн тодорхой хэсэг зэрэг хэд хэдэн төрлийн төлбөр багтдаг.
- Орон нутгийн иргэд, олон нийт** Энэ тайлангийн хувьд аймаг, сумын оршин суугчдыг орон нутгийн иргэд, олон нийт гэж ойлгоно.
- Төлбөр** Энэ нэр томъёог энэхүү тайланд хэд хэдэн утгаар хэрэглэсэн болно. Нэгд, ОУИТБС-ын тайланд тусгагдсан аливаа гүйлгээг, үүний дотор албан татвар, байгаль орчныг нөхөн сэргээх зардал, төрийн болон төрийн бус байгууллагад өгсөн хандив, дэмжлэг, заримдаа борлуулалтын хэмжээ зэргийг нийтэд нь “төлбөр” гэж нэрлэнэ. Хоёрт, “төлбөр” гэдэг нь Монгол Улсын татварын хуулиудын дагуу “албан татвар”-ын нэг төрөл ба нөгөө хоёр төрөл нь татвар, хураамж юм. Түүнчлэн төлбөрийг нэр төрлөөр нь ангилах тохиолдолд “бусад төлбөр” ангиллын дор татвар, төлбөр, хураамж, мөн хандив тусламж, тайлагнасан зардлаас бусад бүх төлбөрийг илэрхийлнэ.
- БХГ** Бүтээгдэхүүн хуваах гэрээ –Газрын тосны хайгуул, олборлолттой холбоотойгоор тухайн компанийн эрх үүргийг болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг талууд хэрхэн хуваан авах тухай Засгийн газар болон газрын тосны компаний хооронд байгуулагддаг гэрээ.
- Төлсөн авснаа нийтэл** Дэлхийн олон улсад үйл ажиллагаагаа явуулдаг, олборлох салбарын ил тод байдал, түүний дотор лиценз, гэрээ, төлбөр, орлогын зарцуулалтын ил тод байдлыг хөхиүлэн дэмждэг иргэний нийгмийн байгууллагуудыг хамарсан эвсэл юм. Монгол Улсын 26 төрийн бус байгууллага “Төлсөн авснаа нийтэл” эвсэлд нэгдэн орж 2006 оноос хойш ОУИТБС, уул уурхайн салбар дахь гэрээ, лицензийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллаж байна.
- Нэгтгэгч** Аудитор-ыг үзнэ үү.
- Нэгтгэл** Компани, Засгийн газрын зүгээс ОУИТБС-ын хүрээнд гаргасан тайланд туссан төлбөр, хүлээн авсан орлогыг баталгаажуулах үйл явц.
- Нэгтгэлийн тайлан** Засгийн газарт компаниудын төлсөн төлбөрийн хэмжээ, нэр төрлийг нарийвчилж нэгтгэн, төлбөр, хүлээн авч орлого хооронд үүссэн аливаа зөрүүг тайлбарласан аудитор буюу нэгтгэгч байгууллагаас бэлтгэсэн тайлан.
- Улсын төсөв** Монгол Улсын Төсвийн тухай хуулинд тодорхойлсноор УИХ-аас баталдаг, засгийн газрын болон улсын төсвөөс санхүүждэг төрийн байгууллагуудын нэгдсэн төсөв гэж ойлгож болно. Улсын болон орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын сангийн ба хүний хөгжил сангийн төсөв хамтдаа Монгол Улсын нэгдсэн төсвийг бүрдүүлдэг. Улсын төсвийн орлого нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн болон нэмүү өртгийн албан татвар зэрэг гол нэр төрлийн татвар, ашигт малтмалын нөөц ашигласны болон лицензийн төлбөр, түүнчлэн газрын тосны салбар дахь бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний орлого зэргээс бүрддэг.

Өмнөх үг

Монгол Улсын хөгжлийн чухал тулгуур болох олборлох салбарт ил тод байдлыг иж бүрэн хангах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна. Уул уурхай, газрын тосны үйл ажиллагаа нь цөөн тооны иргэд, хот суурин, эсвэл зөвхөн нутгийн зон олны аж амьдралд шууд ба шууд бус нөлөөлөөд зогсохгүй нийгэмд бүхэлд нь асар их нөлөө үзүүлж байна. Тиймээс уг салбартай холбогдох мэдээллийг зөвхөн төр засаг, компаниуд, салбарын мэргэжилтнүүд мэддэг, ашигладаг бус, үйл ажиллагааны нөлөөнд нь өртөж буй олон нийт, эрдсийн баялгийн заяамал эзэд болох нийт иргэд хүлээн авдаг, өөрсдийн хэрэгцээндээ ашигладаг байх явдал чухал билээ.

Тодорхой компаниудын төр засагт төлж буй төлбөрийн талаарх мэдээллийг ил тод болгоход Монгол Улсын 2006 оноос хэрэгжүүлж ирсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд багагүй ажил хийгдэж, олон төрлийн өгөгдөл хуримтлагдсан байдаг. Гагцхүү уг мэдээллийг иргэдэд хялбаршуулан хүргэх, дүн шинжилгээ хийж бодлого боловсруулахад ашиглах явдал хангалтгүй түвшинд байна. Энэ байдлыг өөрчлөх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум, олборлох салбарын ил тод байдлын төлөө ажилладаг иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” эвсэл хамтран уг судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Хуримтлагдсан мэдээллийг ашиглахад амар хялбар хэлбэрт оруулах, хийж болох тодорхой дүн шинжилгээг танилцуулах, улмаар уг мэдээллийн ашиглалтыг сайжруулж иргэдэд улам бүр ойртуулахыг зорьсон болно. Түүнчлэн олборлох салбарын мэдээллийн иж бүрэн, нээлттэй байдлыг хангахад бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг хөндөн, зөвлөмж гаргав. Мөн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компанийн мэдээллийг нутгийн иргэд хаанаас олж авах, тус мэдээллийг боловсруулах талаар тусгайлсан зөвлөмж орууллаа.

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэх боломж бүрдүүлж, санхүүгийн дэмжлэг олгосон Дэлхийн Банк, түүний Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагад зориулсан “Олон хандивлагчийн итгэлцлийн сан”-д гүн талархал илэрхийлье. Түүнчлэн судалгаанд шаардлагатай өгөгдлийг гаргаж өгсөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын алба, түүний зохицуулагч Ш. Цолмонд талархаж байна. Судалгааны ажлыг гүйцэтгэх, өгөгдлийг нэгтгэх нүсэр ажлыг хамтран хийсэн “Төлсөн авснаа нийтэл” эвслийн зохицуулагч, “Хил хязгааргүй алхам” төрийн бус байгууллагын тэргүүн Н.Баярсайхан, идэвхитэй оролцсон бусад гишүүд, түүний дотор “Ил тод байдал” сангийн Гүйцэтгэх захирал Д. Цэрэнжав нарын оролцоог онцгойлон дурьдахыг хүсч байна.

Бидний энэхүү судалгаа нь олборлох салбарын ил тод, нээлттэй байдлыг хангах үйлсэд тодорхой хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал

Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачлагын Үндэсний зөвлөлийн гишүүн

1. Оршил



Байгалийн асар их баялагтай Монгол Улс олборлох салбараасаа улам бүр хамааралтай болж байна. Сүүлийн жилүүдэд тус салбар нь улсын эдийн засгийн 20 гаруй хувийг бүрдүүлээд зогсохгүй эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоонд хүрэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл байв. Эдийн засаг, уул уурхайн салбар хүрээгээ улам бүр тэлж байгаа ч иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд үр нөлөө нь тод мэдрэгдэхгүй байна. Өргөн удам нутагт суурилсан, мал аж ахуй давамгайлсан эдийн засагтай, хүн ард нь байгальтай зохицон нөөц баялгаар нь тэжээгдэж олон зуун жил амьдарч ирсэн оронд уул уурхайн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь олон нийтийн дургүйцлийг төрүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлтийн үр шим нь иргэдэд хүртээлгүй мэт байна.

Байгалийн баялгийг зохистой ашиглах, олборлох салбарт иргэдийн хандах хандлагыг өөрчлөхөд тухайн салбарт сайн засаглалыг нэвтрүүлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагад 2006 онд нэгдэн орсон билээ.



гаргах маягтыг хэд хэдэн удаа өөрчиллөө. Мөн ОУИТБС-д болон ОУИТБС-ын нэгтгэлийн тайланд хамрагдсан компанийн тоо ихээхэн нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, өртөг зардал өндөр, төлсөн төлбөрийн хэмжээ материаллаг биш байж болох тул анх ОУИТБС-ын тайлан гаргасан. Мөн Засгийн газрын тайланд хамрагдсан бүх компанийн төлбөрийн мэдээллийг аудитын байгууллага хянаж, нэгтгэсэн эцсийн тайланд оруулахгүй байгаа хэдий ч нэгтгэлд хамруулах материаллаг төлбөрийн хяналтын босго жил ирэх тусам доошилж, улмаар нэгтгэлд хамрах компанийн тоо ихээхэн нэмэгдэж ирсэн билээ. Түүнчлэн ОУИТБС-ын хүрээнд тайлагнах мэдээллийн хамрах хүрээ өргөжиж, компаниас Засгийн газарт төлөх төлбөрөөс гадна хандив дэмжлэг, байгаль орчныг нөхөн сэргээх, ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх зэрэг зардал, бүтээгдэхүүн, борлуулалтын хэмжээ зэрэг нэмэлт мэдээллийг тайлагнаж байхаар маягтад тусгаж өгсөн билээ. Нэгтгэлийн

ОУИТБС нь олборлох компани, Засгийн газар хооронд хийгдэж буй санхүүгийн урсгалын ил тод байдлыг хангах замаар олборлох салбарт ил тод байдлын дэлхий нийтийн стандартыг тогтоохыг зорьж буй. ОУИТБС-ын хүрээнд олборлох компаниуд Засгийн газарт төлсөн төлбөр, Засгийн газар нь компаниудаас хүлээн авсан орлогоо тус бүрдээ тайлагнаж тэдгээрийн чанарыг хөндлөнгийн аудитор харьцуулж нягтлан баталгаажуулдаг.

ОУИТБС-ын шийдвэр гаргахад олон талын оролцоог ханган бүх үйл ажиллагаанд нь засгийн газар, компаниуд, иргэний нийгэм оролцдог. Тиймээс ч ОУИТБС-ын үйл явцын “зүрх” нь тайлан байдаг бол, олон талын оролцоо “сэтгэл” нь юм гэж 40 шахам оронд уг санаачлагыг хэрэгжүүлэх явцад дэмжлэг үзүүлэгч Олон улсын ОУИТБС-ын нарийн бичгийн дарга нарын газраас зүйрлэсэн билээ.

Одоо Монгол Улс ОУИТБС-ын зургаа дахь тайланг бэлэн болгосон ба өмнө нь 2006-2010 оныг хамран таван удаа тайлан гаргасан юм. Энэ хугацаанд ОУИТБС-ын үйл явц ихээхэн төлөвшиж зүгширч ирлээ. Тухайлбал, Засгийн газарт олборлох компаниудын төлөх төлбөрийг зохицуулах хууль тогтоомж өөрчлөгдөж ирсэнтэй холбоотойгоор, түүнчлэн олон нийт, компаниудын зүгээс илүү олон төрлийн мэдээллийг тайланд оруулах хүсэл сонирхолтой байсныг харгалзан үзсэний үндсэн дээр ОУИТБС-ын тайланг

тайланг туршлагатай, тусгайлан сонгогдсон аудитын зөвлөх компаниуд гүйцэтгэж иржээ. Аудитор нь монголын нөхцөл байдлыг сайн мэддэг байх шаардлагыг ОУИТБС-ын оролцогч талууд тавьсны үндсэн дээр сүүлийн жилүүдэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитор болон Монголын аудитын байгууллагын хамтарсан консорциум ажилласан болно.

Харин бидний толилуулж буй энэхүү тайланд ОУИТБС-ын өнгөрсөн хугацааны тайлангуудад хуримтлагдсан өгөгдлүүдийг олон нийт, ялангуяа орон нутгийн иргэдийн зүгээс илүү сонирхож байгаа хэлбэр, ангилалд оруулж тайлбарлан дүгнэлт хийж, ОУИТБС-ын дүрэм, журмыг сайжруулах арга замуудыг санал болгох зорилго тавьсан юм. Тухайлбал, тодорхой компаниас төлөгдсөн төлбөр орон нутгийн засаг захиргаанд очиж байгаа эсэхийг ОУИТБС-ын мэдээллээс харах боломжгүй байгааг дэлгэж харуулав.

Төр засагт олборлох компаниас өгч байгаа төлбөрийн чухал мэдээллийг аудиторын нэгтгэсэн тайлангаас авах боломжтой ч бүх компанийн мэдээллийг нэгтгэж чадахгүй байна. Түүнчлэн жилд нэг удаа бэлтгэгдэн гардаг аудитын тайлан тухайн санхүүгийн жилийн хувьд л хийгддэг тул олборлох компаниудын төлбөрийн өөрчлөлтийг уг тайлангаас ажиглах боломж байхгүй, мөн олборлох салбарын бүх компаниуд уг санаачлагад хамрагдаж чадаж байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байгааг харуулахыг хичээв.

Олборлох салбарыг бүхэлд нь ойлгоход ОУИТБС-ын хүрээнд бүрдсэн өгөгдөл хангалттай биш юм. ОУИТБС-ын гол агуулга болох төр засагт компаниас өгч буй төлбөрийн мэдээллээс гадна уул уурхай, газрын тосны салбарт компани, засгийн газар хооронд байгуулагддаг гэрээ, лиценз, байгаль орчин, нийгмийн үнэлгээний талаарх мэдээлэл иргэдийн хувьд чухал ач холбогдолтой. Цаашилбал, ОУИТБС-ын хүрээнд бий болж буй болон олборлох салбартай холбоотой бусад мэдээллийг эдийн засгийн хүрээнд бүхэлд нь макроэдийн засгийн бусад мэдээлэлтэй харьцуулж ойлгох нь зохимжтой. Тиймээс олборлох салбарын талаарх мэдээллийг бусад мэдээлэлтэй уялдуулан харьцуулснаар тус салбарын эдийн засагт гүйцэтгэж байгаа үүргийг ойлгох боломж бүрдэх юм.

ОУИТБС-ын хүрээнд бий болж буй болон олборлох салбартай холбоотой бусад мэдээллийг эдийн засгийн хүрээнд бүхэлд нь макроэдийн засгийн бусад мэдээлэлтэй харьцуулж ойлгох нь зохимжтой.

Улмаар энэ төслийн хүрээнд бид дараах зорилтыг дэвшүүлсэн юм. Үүнд:

- ОУИТБС-ын хүрээнд тайлан гаргадаг буюу Засгийн газрын тайланд хамрагддаг бүх компаниудын төлбөрийн мэдээллийг судалснаар Монгол Улсын ОУИТБС-д олборлох бүх компаниуд хамрагдаж байх шаардлага хэрэгждэг эсэх, түүнчлэн олборлох салбарын бүх төрлийн төлбөр бүрэн хэмжээгээр санаачлагын хүрээний тайланд хамарч чадаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх.
- Нэгтгэлийн тайлан зөвхөн тухайн санхүүгийн жилийн мэдээллийг агуулдаг тул ОУИТБС-ын мэдээллийг цаг хугацааны хувьд харьцуулан шинжилж дүгнэх ажлыг Монгол Улсад анх удаа хийж гүйцэтгэнэ. Ингэхдээ нэгтгэлийн тайланд агуулагдсан мэдээлэл, шинжилгээг давтах бус, тэдгээрийг улам бүр баяжуулах

замаар ОУИТБС-ын тайлан түүнийг бэлтгэх үйл явцыг илүү сайн ойлгохыг зорьж байна.

- ОУИТБС-ын өгөгдлийн сангийн мэдээллийг макроэдийн засгийн үзүүлэлтүүд, лицензийн өгөгдлийн сангийн мэдээлэлтэй холбох замаар олборлох компаниудын төлбөрийн мэдээллийг ажиллаж буй орчинтой нь уялдуулан таниулах, улмаар олборлох үйл ажиллагаа явагдаж буй орон нутгийн иргэд нутагт нь үйл ажиллагаа явуулж буй компаниуд орон нутгийн засаг захиргаанд нь өгдөг төлбөрүүдийг хянах боломжтой эсэхийг судлах.

Энэхүү тайланг Монгол Улсын бие даасан төрийн бус 26 байгууллагуудын нэгдэл болох Төлсөн Авснаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвслийн зүгээс бэлтгэлээ. ТАН эвсэл нь иргэний нийгмийн 600 гаруй байгууллагын гишүүнтэй олон улсын “Төлсөн авснаа нийтэл” сүлжээний гишүүн, ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцож буй иргэний нийгмийн гол төлөөлөл юм. Энэхүү судалгааны төслийг хэрэгжүүлэх нь ТАН эвслийн ОУИТБС-ын үйл явцад онцгой ач холбогдол өгч байдагтай холбоотойгоос гадна бодлого боловсруулагчид, иргэний нийгэм зэрэг бүх талуудад, нэн ялангуяа олборлох үйл ажиллагааны шууд нөлөөнд өртдөг орон нутгийн иргэдэд зориулан ОУИТБС-ын өгөгдөл мэдээллийг илүү ойртуулах, ашиглах боломжтой болгохыг зорьсон болно.

Тайлангийн хоёрдугаар хэсэгт дүн шинжилгээний гол санал дүгнэлтүүдийг танилцуулж, цаашид ОУИТБС-ын өгөгдлийг илүү ач холбогдолтой, иж бүрэн, ашиглах боломжтой болгох үүднээс ОУИТБС-ын оролцогч талууд чухам ямар алхмуудыг хийвэл зохих талаар тодорхой зөвлөмжүүдийг гаргалаа.

Гуравдугаар хэсэгт ОУИТБС-ын өгөгдлийн сан дахь мэдээллийг ашиглаж хийсэн нарийвчилсан дүн шинжилгээний тайлан, үүний дотор ОУИТБС-д хэн оролцдог, ямар төрлийн, хэдий хэмжээтэй төлбөр хийгддэг, түүнчлэн нэгтгэлийн үйл явц хэр иж бүрэн, юу юуг, хэнийг хамруулдаг талаар мэдээлэл өгнө.

Орон нутгийн иргэдэд хамааралтай мэдээллийг ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн сангаас авах боломжтой.

Дөрөвдүгээр хэсэгт ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн буюу лицензийн өгөгдлийн санг ашиглан ОУИТБС-ын тайлан дахь мэдээллийг баяжуулах, ОУИТБС-ын өгөгдлөөс үзэх боломжгүйнэмэлт мэдээллийг танилцуулах, ялангуяа уул уурхайн компаниудаас тухайн орон нутгийн засаг захиргаанд төлж буй төлбөрийг нутгийн иргэд олж мэдэх боломжтой эсэхийг харуулахыг

зорив. Өөрөөр хэлбэл, орон нутгийн иргэдэд хамааралтай мэдээллийг ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн сангаас авах боломжтойг бид үзүүлэх болно.

Практик ач холбогдлыг нь харгалзан энэ удаад бид зөвхөн 2011 оны өгөгдлийн хувьд л лицензийн болон төлбөрийн мэдээллийг нэгтгэсэн хэдий ч бидний дүгнэлт, зөвлөмж ОУИТБС-ын өгөгдлүүд нь орон нутгийн иргэдэд чухал байх явдлыг нэмэгдүүлэхэд тус нэмэртэй гэдэгт итгэлтэй байна. Тайлангийн төгсгөлд ОУИТБС-ын өгөгдлийн санг судлахад бэлтгэх, судлах үйл явцтай холбоотой арга зүйн асуудлыг тусгасан болно.

2. Дүгнэлт, зөвлөмж



ОУИТБС нь ихээхэн ахиц дэвшил гаргаж байгаа ч салбарын үйл ажиллагааны нөлөөнд автсан нутгийн жирийн иргэд салбарын болон санаачлагын тухай сайн ойлголттой болж, холбогдох мэдээллийг өөрсдийн хэрэгцээнд ашигладаг болохын тулд ихээхэн ажил хийх шаардлагатай байгааг энэхүү судалгаа харуулж байна.

Хамрагдаж буй олборлох компанийн тоо, компаниудаас өгч буй төлбөрийн хувьд 2006-2011 онд ОУИТБС-ын тайлангуудад ихээхэн ахиц дэвшил гарчээ. ОУИТБС-ын тайлангуудад нийт 1000 орчим компанийн мэдээллийг цуглуулжээ. ОУИТБС-д хамрагдах компанийн тоо жилээс жилд нэмэгдэж ирсэн байна. Зарим компаниуд эхний жилүүдэд хамрагдаж байгаад сүүлд больсон байдаг ч шинээр нэгдэн орсон компанийн тоо жил бүр

ОУИТБС-ын тайлангуудад нийт 1000 орчим компанийн мэдээллийг цуглуулсан ба уг санаачлагад хамрагдах компанийн тоо жилээс жилд нэмэгдэж ирсэн байна.

нэмэгдэж байна. Засгийн газарт компаниас өгч буй нийт 83 төрлийн төлбөрийн дүнг ОУИТБС-ын тайлангаас үзэх боломжтой байгаа нь төлбөрийн нэлээд нарийвчилсан мэдээлэл юм. Түүнчлэн олборлох салбарын эдийн засгийн өсөлт, төсвийн орлогод үзүүлж буй нөлөөг ОУИТБС-ын тайлангаас харах боломжтой байна. Тайланг нэгтгэх үйл явц боломжийн түвшинд байгааг анх бэлтгэсэн тайланд нийт төлбөрийн ихэнх

хэсэг буюу 91 хувийг нэгтгэсэн, мөн тайлбарлаж чадаагүй зөрүүний хэмжээ харьцангуй бага байгаа зэргээс харж болно.

Хэдийгээр ахиц амжилтууд байгаа ч нэгтгэн тайлагнаж буй мэдээллийн иж бүрэн, найдвартай байдалд учир дутагдалтай, хүндрэлтэй асуудлууд цөөнгүй байна. Тухайлбал:

- **ОУИТБС-ын хүрээнд цуглуулж, нэгтгэн хадгалж буй өгөгдөл бүрэн бус байна.** Түүнчлэн мэдээллийг хадгалж буй өнөөгийн хэлбэрээр нь цаг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулах боломжгүй байна. Ийнхүү мэдээллийг цаг хугацааны хувьд харьцуулах боломжгүй, иж бүрэн бус байгаа нь холбогдох талууд өгөгдлийг ашиглах боломжийг хязгаарлаж, олон нийтийн зүгээс ОУИТБС-ыг сонирхох байдлыг бууруулж байна.
- **ОУИТБС-д бүх компаниуд оролцохгүй байна.** Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоо өөрсдөө тайлангаа гаргаж буй компанийн тооноос хавьгүй илүү байна. Олон компанийн мэдээлэл нэг бол Засгийн газрын, эсвэл компанийн талд л чиглэгдэж хоёр талаас зэрэг тайлагнахгүй байна. Түүнчлэн хайгуулын, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ч ОУИТБС-д тайлангаа ирүүлэхгүй байгаа олон компани байна.
- **Уран, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд ОУИТБС-д бүрэн хамрагддаг эсэх нь тодорхойгүй байна.** Энэ чиглэлээр ажилладаг компанийн тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газар бус төрийн өөр агентлагууд хянадаг. Ашигт малтмалын газрын зүгээс өөрийн олгодог тусгай зөвшөөрлийн талаар харьцангуй дэлгэрэнгүй мэдээллийг гаргадаг бол уран, газрын тосны лиценз хариуцсан агентлагууд лицензийн мэдээллийг олон нийтэд хүргэхгүй байна. Тиймээс ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн баазуудаас энэ хоёр салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд ОУИТБС-д хамрагддаг эсэхийг мэдэхэд хангалттай мэдээлэл авах боломжгүй байна.
- **Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоо өөрсдөө тайлангаа гаргаж буй компанийн тооноос харьцангуй их байна.** Гэтэл өөрсдөө тайлан гаргаж буй цөөн компанийн Засгийн газарт төлсөн дүн уг компаниудаас Засгийн газрын хүлээн авсан гэж тайлагнасан орлогын дүнгээс их байна. Компаниуд зөвхөн албан ёсны татвар биш, үзүүлсэн хандив дэмжлэгийн талаар Засгийн газраас илүү мэдээлэл ирүүлж байгаагаас гадна хөрөнгө оруулалтын зардал, борлуулалтын хэмжээ зэрэг тайлангийн маягтын “сайн дурын” мэдээллийг нэмж тайлагнасан байна. Засгийн газрын тайлангийн хувьд дээрх мэдээлэл бүрэн бус бүртгэгдсэн

байдаг нь ийм мэдээллийг ОУИТБС-ын тайлангийн хүрээнд бүрэн цуглуулж, олон нийтэд мэдээлэх тухайд хангалтгүй ажиллаж байгааг илтгэнэ.

- **Төлөгдсөн төлбөр нь улсын төсөв, орон нутгийн төсвийн алинд нь тусгагддаг тухай мэдээллийг ОУИТБС-ын өгөгдлөөс шууд авах боломжгүй байна.** Зарим төлбөр орон нутгийн төсөвт төлөгдсөнийг харж болох ч чухам ямар аймаг, сумын төсөвт уг төлбөр төлөгдсөн болохыг мэдэх боломжгүй байна. Ийм төрлийн мэдээлэл нь орон нутгийн засаг захиргаа, иргэдийн болон УИХ-ын гишүүд зэрэг сонирхогч талуудаас ОУИТБС-ыг сонирхох явдлыг нэмэгдүүлэхэд онцгой үүрэгтэй байх болно.

Эдгээр шалтгааны улмаас ОУИТБС нь Монгол Улс дахь олборлох салбарын талаарх бүрэн мэдээллийн итгэж болохуйц эх сурвалж болж хараахан чадахгүй байна. ОУИТБС-ын тайлан жил бүр гарч, аудиторууд төлбөрийн мэдээллийг нэгтгэдэг ч тайлан нь хугацаа алдаж гардаг ба бүх компанийн тайланг нэгтгэхгүй байна. Мөн бүх компани ОУИТБС-д оролцож байгааг хянан нягтлах боломжгүй, хоёр талаас гаргасан анхны тайлан дахь зөрүү их хэмжээтэй, түүнчлэн ОУИТБС-ын тайланд тусгагдсан болон Сангийн яамны уул уурхайн орлогын мэдээлэл зэрэг бусад эх сурвалжаас гаргадаг мэдээллээс зөрдөг зэрэг олон шалтгааны улмаас жирийн хэрэглэгч нь өгөгдлийн үнэн зөвд бүрэн итгэх боломжгүй байна.

Тиймээс ОУИТБС-ын тайлан, өгөгдлийн ашиглалтыг сайжруулах зорилгоор дараах санал зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- ОУИТБС-д олборлох салбарын бүх компаниуд оролцох боломжийг Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг бүрдүүлж хангах шаардлагатай байна. Компаниудын оролцож байгаа түвшин нь ОУИТБС-ын шаардлага, зорилтуудыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ хийхийг санал болгож байна. Үүнтэй холбоотойгоор Засгийн газар лиценз эзэмшигчдийн бүрэн мэдээллийг, үүний дотор уран, газрын тосны лицензийн мэдээллийг ОУИТБС-ын тайланд ил тод нийтлэх ёстой.
- Бүтээгдэхүүн, борлуулалтын хэмжээ, авсан хандив, дэмжлэг, бусад “сайн дурын” төлбөр, тухайлбал хөрөнгө оруулалтын зардал, байгаль орчныг хамгаалахад зориулсан зардал зэргийн хувьд компаниудаас тайлагнаж байгаатай харьцуулахад Засгийн газрын тайланд мэдээлэл тун бага байна. Үүнийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг хянан үзэж, Санаачлагын тайлангийн маягтад мэдүүлэхээр заасан бүх мэдээллийг Засгийн газар нь компанийн нэгэн адил заавал тусгаж байх арга хэмжээг авах шаардлагатай. Түүнчлэн лиценз, бүтээгдэхүүн ба борлуулалт зэрэг тайлангийн маягтын эхний хэсэгт асуусан мэдээллийг бүрэн тайлагнахгүй байгааг хянан үзэх шаардлагатай байна.
- Компаниудын хийсэн төлбөрийг чухам ямар төсөвт, тухайлбал орон нутгийн аль төсөв, түүнчлэн төр захиргааны ямар байгууллагад төлсөн болохыг мэдэх, хянах боломжтой байхаар тайлангийн маягт, үйл явцыг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг шинэчлэн өөрчлөх шаардлагатай.
- Сангийн яам, төр захиргааны бусад байгууллага нь олборлох салбараас хүлээн авсан орлогын тухай гаргадаг мэдээлэлтэй ОУИТБС-ын өгөгдлийг харьцуулан хянаж, мэдээлэл зөрүүтэй байгаа учир шалтгааныг Засгийн газрын зүгээс тайлбарлах шаардлагатай.

- ОУИТБС-ын хүрээнд Засгийн газар, компаниуд, аудиторуудын гаргасан тайлан, мэдээллийг хадгалж буй арга хэлбэрийг өөрчлөх талаар ОУИТБС-ын Ажлын алба анхаарч ажиллах шаардлагатай. Өнөөдөр панел буюу компани, төлбөрийн төрлийг танилцуулсан хэлбэртэйгээр тухайн жилийн өгөгдлийг хадгалж байгаа нь зарим талаар ашигтай ч, өгөгдлийг төлбөр тус бүрийн хувьд кодчилон хадгалах нь оролцогч талууд мэдээллийг хэрэглэх, дүн шинжилгээ хийх явдлыг хялбаршуулж, цаашид ОУИТБС-ын тайлагнал, нэгтгэл, өгөгдлийн хэрэглээг сайжруулахад нөлөөлөх болно.
- ОУИТБС-ын өгөгдлийн санг ашиглан бидний ийнхүү танилцуулж байгаа тайлантай адил төстэй судалгаа, шинжилгээний тайланг Ажлын албанаас бэлтгэж, оролцогч тал, сонирхогч олон нийт тус сангаас мэдээлэл авах боломжтойг харуулах шаардлагатай.
- ОУИТБС-ын өгөгдлийн үнэн зөв, хэрэглэгчид ашиглахад энгийн байдлыг сайжруулах талаар ОУИТБС-ын Ажлын албанаас онцгойлон анхаарах шаардлагатай. Тайлангийн хавсралтаар танилцуулсан өгөгдлийг бататгах тухай хэсэгт бас тодорхой зөвлөмжүүдийг хавсаргасан болно. Тухайлбал, дутуу өгөгдлийг цуглуулах, өгөгдлийг нэг хэлбэрт оруулах, компанийн нэр, төлбөрийн зориулалт зэргийг ижил байдлаар бичих, өгөгдлийг коджуулах зэрэг техник ажлыг Ажлын албанаас хариуцан хийхийг зөвлөж байна.

3. ОУИТБС-ын тайланд тусгагдсан тоо юуг өгүүлнэ вэ?



Энэ хэсэгт ОУИТБС-ын 2006-2011 оны тайлангуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийснийг танилцуулж байна. Тухайлбал, компани болон засгийн газрын тайлагнасан төлбөрийн хэлбэр, хэмжээ, аудиторын гүйцэтгэсэн нэгтгэлийн дүнтэй холбоотой зарим статистик мэдээг танилцуулна. Бид ОУИТБС-ын тайлангаас зарим сонирхолтой, шаардлагатай мэдээллийг тайлбартай танилцуулж, тус санаачлагын өгөгдлийн сангаас авч болох мэдээлэл болон ОУИТБС-ын тайлангийн маягт, мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах зарим санал гаргахыг зорив.

ОУИТБС-ын тайланд хэн хамрагдаж байна вэ?

2006-2011 онд ОУИТБС-ын тайланд нийт 965 компанийн төлбөрийн талаарх мэдээлэл цуглуулжээ. ОУИТБС-ын тайлан гаргах явцад хамрагдсан компанийн тоо жил бүр нэмэгдэж, 2006 онд 150 байснаас 2011 онд 579 болж

өссөнийг Хүснэгт 1-д үзүүлэв. Засгийн газрын тайланд орсон компанийн тоо ОУИТБС-ын тайланг өөрсдөө гаргасан компанийн тооноос хавьгүй илүү байгааг тэмдэглэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ОУИТБС-ын тайлан гаргах нь заавал биелүүлэх үүрэг хэдий ч олон компани энэ үүргээ биелүүлэхгүй байна. Улмаар ОУИТБС-ын хэрэгжилтэд, тухайлбал тайланг нэгтгэх явцад хүндрэл учирч байгаа тул ОУИТБС-ын Үндэсний зөвлөл хяналтаа сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 1. 2006-2011 онд ОУИТБС-ын тайланд хамрагдсан компанийн тоо, тайлагнагч талуудаар

ОУИТБС-ын тайлан	2006	2007	2008	2009	2010	2011
Нийт хамрагдсан компанийн тоо	150	196	221	386	587	579
Засгийн газрын тайлан	137	184	183	358	476	518
Компанийн тайлан	64	102	112	129	268	201

ОУИТБС-ын тайланд хамрагдсан компанийн ихэнх нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бол 2011 оны тайланд хамгийн их буюу газрын тосны (хайгуулын) 13 компани хамрагджээ. Нийт зургаан жилийн хугацаанд газрын тосны 13, уул уурхайн 952 (хайгуулын болон олборлолтын) компанийн тайлан ОУИТБС-ын хүрээнд гарчээ. Газрын тосны салбар ил тод бус байгаатай холбоотойгоор дээрх 13 компани нь Монголд үйл ажиллагаа явуулж буй бүх компани эсэхийг мэдэх боломжгүй байна.

Хүснэгт 2. 2006-2011 онд ОУИТБС-ын тайланд хамрагдсан компанийн тоо, салбар, тайлагнагч талуудаар

Салбар	Тайлагнагч тал	2006	2007	2008	2009	2010	2011
Газрын тос	Засгийн газар	1	3	3	3	8	9
	Компани	1	1	1	2	10	13
	НИЙТ	1	3	3	3	10	13
Уул уурхай	Засгийн газар	63	101	111	127	258	188
	Компани	136	181	180	355	468	509
	НИЙТ	149	193	218	383	577	566

Нийт 965 компаниас 61 (6.3%) нь бүх 6 удаагийн тайланд хамрагдсан байхад, талаас илүү хувь нь ганц удаа ОУИТБС-ын тайлангаа ирүүлснийг Хүснэгт 3-аас харж болно.

Хүснэгт 3. 2006-2011 онд ОУИТБС-ын тайланд хамрагдсан байдал

Тайлангийн давтамж	Компанийн тоо	Нийт дүнд эзлэх хувь
6 удаа	61	6.3
5 удаа	80	8.3
4 удаа	59	6.1
3 удаа	79	8.2
2 удаа	194	20.1
1 удаа	492	51.0
НИЙТ	965	100.0

Нийт компанийн 74 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай байхад цөөн хувь нь хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, хязгаарлагдмал нөхөрлөл, хоршоо хэлбэрээр бүртгэгджээ.

Олон компани ОУИТБС-ын тайланд ганц удаа л хамрагдсан байгаа нь анхаарал татаж, Хүснэгт 4-т эдгээр компани тайланд хэзээ хамрагдсан байдлыг үзүүлэв. Хүснэгтээс жил бүр илүү олон компани ОУИТБС-д шинээр нэгдэж байгааг харж


болно. 2007, 2008 онуудад тайланд хамрагдсан компаниуд ихэнх нь буюу 3-5 компаниас бусад нь хоёр буюу түүнээс дээш удаа тайлан гаргажээ.

Хүснэгт 4. ОУИТБС-ын тайланд нэг удаа хамрагдсан компаниудын тоо, оноор

Он	2006	2007	2008	2009	2010	2011	Нийт
ОУИТБС-н тайланд нэг удаа хамрагдсан компанийн тоо	23	3	5	34	140	287	492

ОУИТБС-ын тайланд хамрагдсан олборлох салбарын компаниудын хариуцлагын хэлбэрийг сонирхон үзвэл Ажлын албанд хадгалагдаж буй мэдээллийн бааз иж бүрэн биш, заримдаа буруу ташаа мэдээлэл агуулсан байгаа нь анхаарал татаж байна. Зураг 1-д үзүүлснээр, нийт компанийн 23 хувь нь хариуцлагын хэлбэрийн талаарх мэдээлэл байхгүй, эсвэл олон янзын хувилбартай байгаа нь харагдаж байна. Нийт компанийн 74 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай (ХХК) байхад цөөн хувь нь хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, хязгаарлагдмал нөхөрлөл, хоршоо хэлбэрээр бүртгэгджээ. Нийт 26 компанийн хувьд хариуцлагын олон хэлбэртэй бүртгэгдсэн байгаа нь тэдгээрийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотой байж болох ч өгөгдлийн сангийн мэдээлэл алдаатай байж болох магадлал илүү өндөр байна. Түүнчлэн компаниуд тухайн төлбөрийг татварын болон төрийн бусад ямар байгууллагад төлдөг болох, компанийн регистрийн дугаар зэрэг мэдээллийн хувьд ч дээрх дутагдлууд нийтлэг ажиглагдаж байв. Зарим жилд ийм мэдээлэл огт байхгүй, заримд нь хагас дутуу байгаа нь уг мэдээллийг ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Зураг 1. ОУИТБС-ын тайланд хамрагдсан компаниуд, хариуцлагын хэлбэрээр



Ямар төрлийн, хэдий хэмжээтэй төлбөр тайлагнагдсан бэ?¹

Ямар төрлийн төлбөрийг, хэдий хэмжээтэй хүлээн авсан, төлснөө Засгийн газар болон компаниуд 2006-2011 онд ОУИТБС-ын хүрээнд хэрхэн тайлагнасан тухай энэ хэсэгт танилцуулахыг зорив.

Компаниудын төлсөн, Засгийн газрын хүлээн авсан төлбөрийн талаарх мэдээллийг Х-д тоймлон харуулав. Нийтдээ 87,658 бие даасан төлбөрийн талаар Засгийн газрын тайлангуудаас олж үзэж болох ба компаниудын тайлагнасан төлбөрийн тоо хэмжээнээс ойролцоогоор хоёр дахин илүү байгаа нь компаниуд өөрсдөө тайлангаа гаргаагүй байлаа ч Засгийн газар тус компанийн мэдээллийг тайланд дэлгэж үзүүлсэнтэй холбоотой. Татвар, төлбөр, хураамж зэрэг хуулиар төлөхөөр заасан төлбөрүүдээс гадна төрийн ба төрийн бус байгууллагад олгосон хандив дэмжлэг, байгаль орчныг нөхөн сэргээхэд болон ажиллагсдыг сургахад зарцуулсан зардал, хөрөнгө оруулалтын зардал зэрэг нэмэлт мэдээлэл ч энэхүү төлбөрийн мэдээллийн санд байгааг тэмдэглэх хэрэгтэй. Оролцогч талууд, түүний дотор уул уурхайн үйл ажиллагааны шууд нөлөөнд байдаг нутгийн иргэдэд чухал ач холбогдолтой учраас ийм төрлийн мэдээллийг ОУИТБС-ын тайлангийн маягтанд тусгаж өгсөн билээ.

Дээрх хугацаанд Засгийн газрын тайлагнасан нийт төлбөрийн хэмжээ 5.146 их наяд төгрөг байгаа бол компаниудын тайлагнасан нийт дүн үүнээс 2.75 дахин илүү юм. Улмаар компаниудын тайлагнасан төлбөрийн дундаж хэмжээ нь Засгийн газрын тайлангийнхаас ихээхэн давж байна. Тайлагнасан хамгийн том төлбөрийн хэмжээ нь 4 их наяд төгрөг байгаа нь Оюутолгой төслийн 2011 оны нийт хөрөнгө оруулалтын хэмжээг компани өөрөө тайлагнасан дүн юм. ОУИТБС-ын тайлангийн маягтын сайн дурын мэдээллийн хэсэгт хөрөнгө оруулалтын зардал зэрэг зарим нэмэлт мэдээллийг тайлагнахаар заажээ. Дараагийн хамгийн том хэмжээтэй төлбөр нь мөн л засгийн газрын төлбөр бус, бүр зардал ч биш, харин Эрдэнэт ХХК-ний 2007 онд тайлагнасан борлуулалтын нийт нэг их наяд төгрөг юм. Энэ хоёр мэдээлэл нь дүн шинжилгээний нэгдсэн дүнд ихээхэн нөлөөлөхүйц, дээд үзүүлэлт тул шаардлагатай тохиолдолд нэгдсэн дүнгээс хасч, холбогдох дүгнэлтийг тусд нь хийсэн болно. Гэхдээ энэхүү их хэмжээний төлбөрийн талаар Засгийн газрын тайланд тусгаагүй нь анхаарал татаж байна. ОУИТБС-ын тайлангийн хүрээнд их хэмжээний төлбөрийн мэдээллийг тайлагнаж, үр дүнг нь аудитор нэгтгэж байх нь чухал ач холбогдолтой. Цөөн хэдэн төлбөрийн хувьд сөрөг дүнтэй төлбөр бүртгэгдсэн нь ОУИТБС-ын тайлан бэлэн мөнгөнд суурилсан, мөн компани, Засгийн газар хоорондын татварын тохируулгатай холбоотой байх боломжтой.

Хүснэгт 5. Төлбөрийн тойм

Үзүүлэлт	Засгийн газар	Компани	Нийт	Зөрүү	Харьцаа
Бие даасан төлбөрийн тоо	87,658	43,160	131,488	(44,498)	0.49
Төлбөрийн нийт хэмжээ	5,146,249,937	14,143,853,750	19,252,552,671	8,997,603,813	2.75
Төлбөрийн дундаж хэмжээ	58,708	327,707	146,421	268,999	5.58
Хамгийн их утгатай төлбөр	398,297,997	4,124,827,165		3,726,529,168	10.36
Хамгийн бага утгатай төлбөр	(7)	(6,047,622)		(6,047,615)	861,190.21
Стандарт хазайлт	2,841,332	21,050,855	12,282,275	18,209,523	7.41

¹ Бүх төлбөрийн дүн нь тусгайлан тайлбарлаагүй бол мянган ('000) төгрөгөөр илэрхийлэгдсэн. ОУИТБС-ын тайланд зарим төлбөрийг ам. доллараар гаргадаг ч тухайн жилийн албан ёсны валютын ханшаар тооцон мянган төгрөгөөр илэрхийлсэн болно.

Төлбөрийн хэмжээгээр тооцвол Засгийн газрын тайлангийн ихэнх хэсгийг суурь буюу заавал тайлагнах мэдээлэл эзэлж байгаа бол компанийн тайланд суурь мэдээллээс гадна хандив дэмжлэг, бусад зардал зэрэг төрөл бүрийн мэдээлэл орсон байгааг Хүснэгт 6-аас харж болно. Хамгийн их утгатай хоёр төлбөрийг хасвал суурь мэдээлэл нь компаниудын тайлангийн 62.3 хувийг бүрдүүлж, Засгийн газрын тайлан дахь суурь мэдээллийн хэмжээнээс ихээхэн бага байгаа

Нэг талаас, төр засгийн байгууллагад компаниудын төлсөн болон орон нутгийн хөгжилд зориулсан аливаа төлбөрийг бүрэн дүүрэн мэдээлэх сонирхолтой байдгийг ойлгож болох ч нөгөө талаас, Засгийн газрын хувьд хүлээн авч буй хандив, дэмжлэг, мөн иргэдэд ашиг тустай байж болох зарим зардалтай холбоотой мэдээллийг төр засгийн зүгээс тайлагнах явдал хангалтгүй байгаа нь анхаарал татсан асуудал юм.

Хүснэгт 6. Төлбөрийн ангилал, тайлагнагч талуудаар

Мэдээллийн төрөл	Засгийн газар	Компаниуд	Компаниуд (хамгийн их 2 төлбөрийг хассан дүн)
Суурь мэдээлэл	99.9%	39.7%	62.3%
Сайн дурын мэдээлэл	0.1%	46.5%	27.2%
Бусад мэдээлэл	0.0%	13.8%	10.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%

Засгийн газарт компаниудын төлөх албан ёсны төлбөрүүд нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгддэг татвар, төлбөр, хураамжийн хэлбэртэй байдаг. Төлбөр нь улсын болон орон нутгийн төсөвт ордог. ОУИТБС-ын тайлангийн хүрээнд энэхүү албан ёсны төлбөрөөс гадна сайн дурын үндсэн дээр компаниас төр засгийн байгууллагад, мөн нийгмийн болон орон нутгийн иргэдийн тусын тулд хийгддэг төлбөрүүдийг хамруулахыг зорьсон юм. Засгийн газрын тайлагнасан нийт төлбөрийн 90 хувь нь улсын төсөвт, дөнгөж 1.7 хувь нь орон нутгийн төсөвт, 7.8 хувь аль төсөвт орсныг шууд тогтоох боломжгүй байна. Компаниудын хувьд хөрөнгө оруулалтын зардал зэрэг сайн дурын мэдээлэл их байгаа тул улсын төсөвт оруулсан хувь нэмэр нь Засгийн газрын тайлангийнхаас илүү байгааг Хүснэгт 7-оос харж болохоор байна.

Хүснэгт 7. Төлбөрийн зориулалт, тайлагнагч талуудаар

Төлбөрийн зориулалт	Засгийн газар	Компаниуд
Улсын төсөв	90.1%	32.1%
Орон нутгийн төсөв	1.7%	1.7%
Хандив, дэмжлэг	0.4%	0.6%
Бусад төлбөр	7.8%	65.7%


Төлбөрийн мэдээллийг гүнзгийрүүлэн судалбал Засгийн газрын тайланд татварын орлого 62.88 хувь, харин компаниудын тайланд 22.73 хувь байгааг Хүснэгт 8-д танилцуулав. Засгийн газрын тайланд “сайн дурын” мэдээлэл огт байхгүй биш, бага байгаагаас харахад ийм төрлийн мэдээллийг цуглуулж, тайлагнах тухайд Засгийн газар хангалтгүй ажиллаж байгааг гэрчилнэ.

Хүснэгт 8. Төлбөрийн төрөл, тайлагнагч талуудаар


Төлбөрийн төрөл	Засгийн газар	Компаниуд	Компаниуд (2 төлбөрийг хассан дүн)
Татвар	62.88%	22.73%	35.63%
Төлбөр	23.18%	8.47%	13.28%
БХГ-ний дагуух төлбөр	2.59%	2.35%	3.69%
Хураамж, үйлчилгээний хөлс	1.18%	0.47%	0.74%
Бусад төлбөр	0.33%	0.92%	1.44%
Ногдол ашиг	6.55%	2.83%	4.44%
Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг	0.37%	0.48%	0.75%
Бусад байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэг	0.01%	0.07%	0.11%
Нийгмийн даатгал	2.41%	0.81%	1.27%
Байгаль орчныг хамгаалах зардал	0.43%	0.35%	0.55%
Бусад зардал	0.08%	60.52%	38.11%
Нийт	100.00%	100.00%	100.00%

Засгийн газар, компанийн тайланд орсон төлбөрийн нийт хэмжээ жилээс жилд нэмэгдсэн дүнтэй байсныг Зураг 2-оос харах боломжтой. Ялангуяа 2009 оноос хойш компаниудын тайлагнасан төлбөрийн дүн ихээхэн нэмэгдсэн нь цөөн хэдэн компанийн ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний борлуулалтын дүнтэй холбоотой.


Зураг 2. Компани, Засгийн газрын тайланд орсон төлбөрийн харьцуулалт



Зураг 3-т Засгийн газрын тайланд орсон төлбөрийн мэдээллийг дэлгэрүүлж задлан танилцуулав. Засгийн газрын хүлээн авсан төлбөрийн томоохон хэсгийг татвар бүрдүүлж байгаа ч жил ирэх тутам хувийн жин нь буурч байгаа нь харагдаж байна. Дараагийн томоохон үзүүлэлт нь нөөц ашигласны төлбөр зэргийг оруулсан төлбөрүүд ба эдгээрийн хувийн жин нэмэгдэж байна. Гуравдахь чухал төлбөр бол ногдол ашиг бөгөөд хувийн жин нь анхны 2006 онтой харьцуулахад буурч иржээ. Анх ОУИТБС-ын тайланг гаргаж байх үетэй харьцуулахад Засгийн газрын хүлээн авч буй төлбөрийн нэр төрөл олширсон болохыг сүүлийн үеийн тайлангуудаас харах боломжтой байна.



Тодорхой авч үзвэл нийт 83 төрлийн төлбөрийн мэдээллийг ОУИТБС-ын тайланд зургаан жилийн хугацаанд хамруулжээ. Зураг 4-т тодорхой төлбөрийн төрөл нь тайлангуудад хамрагдсан байдлыг үзүүлэв. Тухайлбал, 23 төрлийн төлбөр бүх зургаан тайланд хамрагдсан, харин зургаан төрлийн төлбөрийг маягтын дагуу тайлагнах ёстой ч төлсөн гэж тайлагнагдсан тохиолдол байхгүй байна.



2011 оны жишээгээр төлбөрийн дундаж дүнг авч үзвэл хөрөнгө оруулалтын зардал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар, компанийн ашгийн татвар зэрэг нь хамгийн их дүнтэй байгааг Хүснэгт 9-өөс харах боломжтой.

2006-2011 онд ямар компани хэдий хэмжээний төлбөр төлсөн болохыг Хүснэгт 10-аас харах боломжтой.

Бусдаас хамгийн их төлбөр төлсөн Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэр энэ хугацаанд 2.7 их наяд төгрөгийн төлбөрийг тайландаа тусгажээ. Дараа нь зэс алтны томоохон ордыг ашиглах бэлтгэлээ хангаж буй Айвенхоу Майнз /Оюу Толгой/, нүүрсний Таван Толгой компаниуд, мөн алт олборлогч Монголын Алт Корпораци, Бороо Голд компаниуд хамгийн их төлбөр төлжээ. 10 компани ямар ч татвар огт төлөөгүй хэдий ч мэдээллийг нь Засгийн газрын зүгээс ОУИТБС-ын тайланд оруулсан баримт байна.

Хүснэгт 9. Засгийн газар, компаниудын тайланд тусгагдсан хамгийн их дундаж хэмжээтэй төлбөрийн төрлүүд

Төлбөрийн нэр	Дундаж хэмжээ
Хөрөнгө оруулалтын зардал	6,180,104.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	1,324,609.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	977,960.9
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	793,192.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар (гааль)	657,040.0
Роялти (газрын тос)	400,715.0
Геологи, хайгуулын зардал	306,060.9
Гаалийн татвар	268,432.6
БХГ-ний дагуу Засгийн газарт ногдох бүтээгдэхүүн	262,325.3
Нэмэгдсэн өртгийн албан татвар (татварын алба)	183,222.8
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	180,446.2
Гэнэтийн ашгийн татвар	156,092.9
Торгууль	140,080.8
Төрийн өмчийн ногдол ашиг	130,903.1
Бусад татвар	113,531.0
Бусад бүх төлбөрийн дундаж дүн	11,967.8

Хүснэгт 10. Хамгийн их төлбөр төвлөрүүлэгч компаниуд, Засгийн газрын тайлагнаснаар (сая төгрөг)

Хамгийн их төлбөр төлөгч компани	2006	2007	2008	2009	2010	2011	Нийт
Эрдэнэт	172582.0	599962.6	549631.1	264391.6	608430.6	545780.3	2740778.3
Айвенхоу Майнз (Оюу Толгой)	2.7	5830.3	1611.7	1292.6	36231.2	438757.9	483726.4
Таван Толгой	2657.4	10864.1	18551.3	38563.3	58460.1	171354.6	300450.9
Монголын Алт Корпораци	370.0	824.9	5509.3	20602.2	89883.9	157779.3	274969.6
Бороо Голд	92.1	46890.2	29694.3	37544.9	45721.2	16520.5	176463.1
Энержи Ресурс	0.0	0.0	0.0	13381.5	31466.3	80213.4	125061.2
Петрочайна Дачин Тамсаг	36.1	1033.1	1408.0	1676.9	40395.8	58260.0	102810.0
Цайрт Минералз	3011.0	8432.9	19530.8	13140.4	34084.2	22740.4	100939.8
Болд Төмөр Ерөө Гол	0.0	637.4	6808.6	12044.4	35727.1	38945.1	94162.6
Саусгоби Сэндс	0.0	0.0	0.0	13727.0	7726.3	54012.4	75465.7
Алтан Дорнод Монгол	459.9	31473.3	11102.3	277.3	306.0	1076.5	44695.4
Чинхуа Мак Нарийн Сухайт	45.5	879.8	4246.1	4472.6	9953.1	20212.3	39809.5
Доншень Ойл	0.0	123.0	86.9	192.0	17524.9	19522.6	37449.4
Магнай Трейд	0.0	0.0	0.0	0.0	0.0	35673.5	35673.5
Монросцветмет	301.8	3415.5	4555.2	2647.1	9545.6	7115.4	27580.4
Алтайн Хүдэр	0.0	0.0	0.0	103.1	4169.5	19565.5	23838.1

Засгийн газрын тайлагнасан төлбөрийн дүнгээс харахад хамгийн их татвар төлсөн 10 компани нь зургаан жилийн хугацаанд нийт 4.47 их наяд төгрөгийг Засгийн газарт төлсөн нь үлдсэн 816 компанийн төлсөн дүнгээс даруй 6.7 дахин их байгааг Хүснэгт 11-д танилцуулав. Өөрөөр хэлбэл, хамгийн том 10 компани нь тооны хувьд Засгийн газрын тайланд орсон компанийн 0.1 хувь хэдий ч нийт төлбөрийн 87 орчим хувийг төлсөн дүн харагдаж байна.


Зургаан жилийн хугацаанд нэг компанийн төлсөн төлбөрийн дундаж хэмжээ хамгийн том 10 компанийн хувьд 447.5 тэрбум төгрөг байхад үлдсэн компаниудынх 822.8 сая төгрөг байна. Энэ дүнгээс харахад Монгол Улсад том, жижиг уурхайн үүрэг оролцооны талаарх асуудал сөхөгдөх боломжтой ч бид энэ асуудлыг уг тайланд нягтлан шинжлэхийг зориогүй, харин иймэрхүү шинжилгээ дүгнэлт хийхэд мэдээллийг ашиглах боломжтойг харууллаа.

Хүснэгт 11. 2006-2011 онд хамгийн их төлбөр төвлөрүүлсэн 10 компанийн төлбөрийг бусад компаниудынхтай харьцуулсан байдал, Засгийн газрын тайлагнаснаар

	Топ 10 компани	Бусад 816 компани
Нийт төлбөр	4,474,827,487	671,422,450.1
Нийт төлбөрт эзлэх хувь	87%	13%
Дундаж төлбөрийн хэмжээ	447,482,749	822,821.6

Дараагийн гурван зурагт ОУИТБС-ын хүрээнд цугласан мэдээллийг макро эдийн засгийн зарим чухал үзүүлэлтүүдтэй харьцуулж харуулахыг зорив. Тухайлбал, уул уурхайн компаниудын төлбөрийн ДНБ-д эзлэх хувийг Зураг 5-д харуулсан ба уг хэмжээ Засгийн газрын тайлагнаснаар 2006 онд 5.3 хувьтай тэнцэж байсан бол 2011 оны байдлаар 18.6 хувь болон нэмэгдсэн ба компаниудын тайлагнаснаар 17.4 хувиас 60.1 хувь болон өсчээ. Ийнхүү компаниуд Засгийн газраас хавьгүй илүү хэмжээний төлбөрийг тайлагнасан нь сайн дурын мэдээллийг компаниуд тусгасан байхад Засгийн газар өөрийн тайландаа тусгаагүйтэй холбоотой.

Зураг 5. ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийн ДНБ-д эзлэх хувь



ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийг засгийн газрын төсвийн орлоготой харьцуулж Зураг 6-д харуулав. Засгийн газарт олборлох салбарын компаниуд 2011 онд төсвийн орлогын 45.3 хувьтай тэнцэх төлбөрийг төлсөн гэж Засгийн газар тайлагнасан байхад компаниуд өөрсдөө тайлагнасан дүнгээс харахад 2007 онд төсвийн орлогоос давсан дүн буюу 166 хувьтай тэнцэх хэмжээний төлбөр тусгагджээ.

Зураг 6. ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийн нэгдсэн төсөвт эзлэх хувь



Цаашилбал, Зураг 7-д үзүүлснээр Сангийн яамны хүлээн авсан уул уурхайн орлого хэмээн албан ёсоор танилцуулсан тоо мэдээлэлтэй ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийн дүнг харьцуулахад, энэ хоёр тоо ихээхэн зөрж байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, 2011 онд компаниудын тайлагнасан дүн нь уул уурхайн орлогын дүн мэдээнээс 5.16 дахин их байсан бол Засгийн газрын тайлагнасан дүн мэдээ ч яамны албан ёсны тоо мэдээнээс даруй 59.6 хувиар илүү байв. Гэхдээ уул уурхайн орлогыг тооцож байгаа Сангийн яамны аргачлал төгс биш, мөн ОУИТБС-ын хүрээнд зөвхөн төсөвт төлсөн төлбөр бус, албан бус хандив дэмжлэг зэргийн мэдээлэл орсон байдаг, түүнчлэн газрын тосны салбарын орлого тусгагддаг тул шууд харьцуулах боломжгүйг дурдах нь зүйтэй.

Зураг 7. ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрийг уул уурхайн төсвийн орлогын хэмжээтэй харьцуулсан дүн



ОУИТБС-ын тайланг нэгтгэх үйл явц

2006-2010 онд ОУИТБС-ын нэгдсэн тайланг нийт таван удаа бэлтгэгдсэн юм. Энэ хугацаанд 781 компанийн мэдээлэл ОУИТБС-ын хүрээнд тайлагнагдсанаас 185 буюу 23.7 хувийг нь нэгдсэн тайланд хамруулсан болохыг Хүснэгт 12-т

танилцуулав. Анхны тайлангуудад хамрагдсан компаниудаас нэгтгэлд орсон компанийн тоог тодорхой оноор судлан үзвэл энэхүү дундаж хэмжээ бага зэрэг өссөн ч уг дундаж хэмжээ бага хэвээр байгаа нь олон тооны компаниуд өөрсдөө ОУИТБС-ын тайлангаа гаргадаг, эсвэл тэдний тухай мэдээллийг Засгийн газар ОУИТБС-д гаргаж өгдөг тайландаа тусгадаг хэдий ч эцсийн нэгтгэл хийгдсэн тайландаа хамруулаагүй байгааг илтгэнэ.

Нэгтгэлийг гүйцэтгэгч аудиторууд хэдэн компанийг нэгтгэлд хамруулсан мэдээлэл нь зарим тохиолдолд Засгийн газар, компаниудын анх гаргасан тайлангаас зөрөх тохиолдол байгаа нь анхаарал татаж байна. 2006 онд “Монгол Газар” ХХК ОУИТБС-ын нэг л тайлан гаргасан байхад нэгтгэгч аудитор тус компанийн хувьд хоёр тусдаа нэгтгэл хийсэн нь “Монгол Газар Холдинг” ХХК хэмээх салбар компанийг тусд нь авч үзсэнтэй холбоотой ажээ. 2010 онд “Тэн Хун” компани өөрөө анхны тайлангаа гаргаагүй, мөн Засгийн газрын тайланд ч тус компанийн тухай мэдээлэл байхгүй байхад

нэгтгэлийг хийсэн аудитын компанийн тайланд уг компанийн мэдээлэл орсон байна. Тиймээс дээрх хүснэгтэд танилцуулсан нэгтгэлд хамрагдсан компанийн тоо нь 2006, 2010 онуудад хоёр тохиолдолд ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангийн дүнгээс зөрж байна.

Хүснэгт 13. Нэгтгэлд хамрагдсан компанийн тоо, давтамж

Нэгтгэгдсэн давтамж	Компанийн тоо
5	16
4	10
3	16
2	44
1	99
Нийт	185

Хүснэгт 12. ОУИТБС-д оролцогч компанийн тоог ОУИТБС-ын нэгдсэн тайланд хамрагдсан компанийн тоотой харьцуулсан байдал

Он	Компани				Нийт Тоо
	Нэгтгэлд хамрагдсан		Нэгтгэлд хамрагдаагүй		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
НИЙТ	185	23.7%	596	76.3%	781
2006	24	16.0%	126	84.0%	150
2007	38	19.4%	158	80.6%	196
2008	45	20.3%	177	79.7%	222
2009	101	26.2%	285	73.8%	386
2010	149	25.4%	438	74.6%	587

Нийт 185 компанийн өгөгдлийг хөндлөнгийн аудитор таван жилийн хугацаанд ОУИТБС-ын хүрээнд нэгтгэснээс 86 компанийн тайланг хоёр ба түүнээс дээш жилд олон удаа нэгтгэлийн тайланд хамруулсан бол нийт 16 компанийн мэдээлэл бүх таван удаагийн нэгтгэлд хамрагджээ.

Засгийн газар, компаниудын тайлагнасан дүнгийн хоорондын зөрүүг авч үзвэл таван жилийн дотор нийт 11.9 их наяд төгрөгийн зөрүү анхны тайлангуудад гарчээ. Энэхүү зөрүүний 91 хувийг нэгтгэлийн үйл явцын хүрээнд тайлбарласан гэж үзэж болно. Харин нэгтгэлийн хүрээнд авч үзсэн зөрүүний нэг хувийг аудиторууд шийдвэрлэж чадаагүй, өөрөөр хэлбэл, шалтгааныг нь тайлбарлаж чадаагүй болохыг Хүснэгт 14-т танилцуулав.

Хүснэгт 14. Анхны тайлангийн болон шийдвэрлэгдээгүй зөрүүний дүн

Он	Анхны зөрүү	Нэгтгэлээр нягталсан зөрүү (хувь)	Шийдвэрлэсэн зөрүү	Шийдвэрлээгүй зөрүү	Шийдвэрлээгүй зөрүү (хувь)
2006	488,039,851.58	97%	440,834,188.76	32,151,129.73	6.8%
2007	2,567,758,022.34	97%	2,463,817,473.26	16,653,241.00	0.7%
2008	1,013,060,464.39	72%	723,118,451.70	4,399,193.00	0.6%
2009	854,680,717.46	92%	786,408,546.13	64,797.00	0.0%
2010	782,024,085.29	95%	738,896,593.08	1,214,772.80	0.2%
2011	6,233,655,474.65	-	-	-	-
Нийт	11,939,218,615.71	91%	5,153,075,252.94	54,483,133.53	1.0%

4. Орон нутгийн иргэд ямар мэдээлэл авах боломжтой вэ?



ОУИТБС олборлох салбар, олборлох үйл ажиллагаанаас төр засагт өгч буй орлогын талаар ихээхэн мэдээллийг нийтэлж ирсэн бөгөөд цугласан мэдээллийг ашиглан хийж болох дүн шинжилгээний зарим жишээг өмнөх хэсэгт танилцуулсан. Гэсэн хэдий ч ОУИТБС-ын өгөгдлийн сангийн том дутагдал нь төлбөрийн мэдээллийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй холбон харах шууд боломжгүй, мөн тухайн аймаг сумд, тэдгээрийн засаг захиргаанд өгч байгаа төлбөрийг мэдэх боломжгүй байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, суманд амьдарч буй иргэн нутагт нь уул уурхайн ямар компани үйл ажиллагаа явуулдаг, тэдгээр компани нь орон нутгийн засаг захиргаанд хэдий хэмжээтэй, ямар төрлийн төлбөрүүдийг төлдөг талаар тодорхой мэдээлэл авч чаддаггүй байна. Энэ асуудлыг нарийвчлан судлах зорилгоор ОУИТБС-ын өгөгдлийг бусад мэдээлэлтэй холбон ашиглах, тухайлбал Ашигт малтмалын газраас гаргадаг тусгай зөвшөөрлийн мэдээлэлтэй уялдуулахыг зорьлоо.

Тусгай зөвшөөрлийн буюу лицензийн өгөгдлийн санд лиценз эзэмшигч, лицензийн хамрах талбайн байршил, хэмжээ, лицензийн төрөл зэрэг мэдээлэл агуулагддаг.

Тусгай зөвшөөрлийн буюу лицензийн өгөгдлийн санд лиценз эзэмшигч, лицензийн хамрах талбайн байршил, хэмжээ, лицензийн төрөл зэрэг мэдээлэл агуулагддаг. Тиймээс ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн санд байгаа нийтлэг мэдээллийг ашиглан ОУИТБС-ын өгөгдлийг лицензийн мэдээллийн сангийн өгөгдлөөр баяжуулах боломжтой.

Ингэснээр иргэдэд илүү ойр ямар мэдээллийг олон нийтэд хүргэж болохыг судлах зорилгоор энэ хоёр өгөгдлийн санг лиценз эзэмшигч, төлбөр төлөгч компанийн мэдээллээр дамжуулан нэгтгэх ажлыг туршиж үзсэн бөгөөд практик ач холбогдол, боломжийг бодолцож зөвхөн нэг жилийн буюу 2011 оны өгөгдлийг л нэгтгэсэн болно.

Лицензийн мэдээлэл нь зөвхөн уул уурхайн салбар дахь хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг хамрах бөгөөд газрын тос, цөмийн эрчим хүчний салбарын мэдээлэл ороогүй болохыг тэмдэглэж байна. Энэ төрлийн лицензүүдийг Ашигт малтмалын газар бус асуудал хариуцсан өөр байгууллагууд, тухайлбал газрын тосны, цөмийн эрчим хүчний агентлагууд хариуцдаг ба газрын тосны лицензийн тухай мэдээлэл олон нийтэд ил тод бус, харин ураны лицензийн хувьд 2012 оны байдлаар 16 компани лиценз эзэмшиж байгаа мэдээлэл байдаг ч энэ нь ил тод биш байна.

2011 оны эхэнд 1904 компани Ашигт малтмалын газраас олгодог ашигт малтмалын лицензийг эзэмшиж байв. Эдгээр компаниас зөвхөн 511 буюу ердөө 27 компанийн мэдээлэл л ОУИТБС-ын тайланд оржээ. Өөрөөр хэлбэл, олон компани ОУИТБС-д оролцохгүй, эсвэл лиценз эзэмшдэг ч ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй байгаа дүр төрх харагдаж байна. Үлдсэн 1393 компанийн хувьд лиценз эзэмшдэг хэдий ч ОУИТБС-ын тайланд оролцохгүй байгаа нь уг санаачлагад бүх компани оролцох шаардлага хэрэгжиж байгаа эсэх, оролцохгүй байгаа компани материаллаг төлбөр төлдөг эсэх талаар хянан нягтлах шаардлагатай байна. Дээрх 511 компаниас гадна газрын тосны 13, ураны 4 компанийн мэдээлэл ОУИТБС-ын хүрээнд цугласан буюу нийт 528 компани болж байна. Түүнээс гадна өөр 49 компанийн² мэдээлэл ОУИТБС-ын тайланд орсон байгаа ч лиценз эзэмшдэг тухай мэдээлэл байхгүй байна. Өөрөөр хэлбэл, эдгээр 49 компани нь лицензгүй үйл ажиллагаа явуулдаг, бусдын эзэмшдэг лицензийн хүрээнд ажилладаг ба ОУИТБС-ын тайланг харин өөрийнхөө нэрээр гаргасан болж таарч байна. ОУИТБС-ын хүрээнд лиценз эзэмшигч бүх компани тайлан гаргах ёстой учир энэ 49 компанийн мэдээллийг ОУИТБС-ын Ажлын алба, 2011 оны тайлангийн аудиторууд дэлгэрүүлэн нягтлах ёстой. Энэ хэсэг дэх дүн шинжилгээ нь ОУИТБС-ын хүрээнд тайлан гаргасан, лицензийн өгөгдлийн санд мэдээлэл нь багтсан 511 компанийн хүрээнд хийгдсэн болно.

Компаниудын эзэмшиж буй лицензийг төрлөөр нь Хүснэгт 15-д танилцуулсан. 2011 онд ОУИТБС-ын тайланд хамрагдсан 511 компани нийтдээ 2488 лиценз (нийт 4129 бүртгэлтэй лицензийн дөнгөж 60 орчим хувь нь) эзэмшиж байгаагаас 72.7 хувь нь хайгуулын, харин 27.3 хувь нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байна. Дунджаар нэг компани тав орчим лиценз эзэмшдэг байна.


² Ураны болон газрын тосны салбарын лицензийн мэдээлэл олон нийтэд хаалттай; тиймээс эдгээр компани энэ хоёр чиглэлийн лицензтэй байх боломжтой.

Хүснэгт 15. ОУИТБС-ын 2011 оны тайланд хамрагдсан компаниудын эзэмшдэг лицензийн тоо, төрөл

Ашиглалтын лиценз	Хайгуулын лиценз	Нийт	Нэг компанид ногдох дундаж
680	1808	2488	4.87
27.3%	72.7%	100%	

Дээрх ашиглалтын 680 лиценз нь нийт 29 төрлийн ашигт малтмалыг хамардаг. ОУИТБС-д хамрагдсан компаниудын олборлодог ашигт малтмалын төрлийг Зураг 8-д үзүүлэв. Нийт алтны ашиглалтын 340 лиценз олгогдсон бөгөөд нүүрс, барилгын материалын лицензийн тоо удаалж байна.

Зураг 8. ОУИТБС-ын 2011 оны тайланд орсон компаниудын олборлож буй ашигт малтмалын төрөл



ОУИТБС-ын тайланд хамрагдсан компаниудын эзэмшдэг лицензийн талаарх статистик мэдээллийг дор танилцуулж байна. Засгийн газарт компаниудаас өгдөг төлбөр, тухайн компаниудын лицензээр эзэмшдэг талбай хоёрын хооронд статистик хамаарал бага байна. Нэг га талбайд ногдох төлбөрийн хэмжээ 5.2 сая төгрөг байна. ОУИТБС-ын тайланд оролцогч компаниуд нэг бус хэд хэдэн аймагт лиценз эзэмших нь элбэг байгаа тул тухайн лиценз эзэмшигч нь ОУИТБС-ын хүрээнд орон нутагт өгсөн гэх төлбөрийг яг тодорхой нэг аймаг, суманд очсон эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Хүснэгт 16. ОУИТБС-ын тайланд хамрагдсан компаниудын эзэмшдэг лицензийн талаарх зарим статистик мэдээлэл

511 компанийн статистик мэдээлэл	Дүн
Төлбөр, талбайн хэмжээ хоорондын корреляци хамаарал	-0.00031
Нэг га талбайд ногдох төлбөрийн дундаж хэмжээ (Засгийн газрын тайлагнаснаар)	5,225,906 төг
ОУИТБС-д хамрагдсан, хоёр буюу түүнээс дээш аймагт лиценз эзэмшигч компанийн тоо	187
ОУИТБС-д хамрагдсан, нэг аймагт лиценз эзэмшиж буй компанийн тоо	324

Хүснэгт 17. Хамгийн олон аймагт лиценз эзэмшиж буй компаниуд

Компани	Лиценз эзэмшиж буй аймгийн тоо
Тефис Майнинг	11
Их Монгол Майнинг	11
МРС МГ	10
Пибоди Винсвэй Ресорсес	9
МАК	9
Бэрх Ресорсес	9
Адамас Маунтэйн	9
Самтан Морз	8
Содгазар	8
Орчлон Орд	8
Гацуурт	7
Нийслэл Өргөө	7
Эрэл	7

Хамгийн олон аймагт үйл ажиллагаа явуулах лиценз эзэмшиж буй компаниудын жагсаалтыг Хүснэгт 17-д танилцуулсан ба үүнээс орон нутгийн иргэд өөрсдийн засаг захиргаанд тухайн компаниас төлсөн төлбөрийг хянах боломж муутай нь харагдаж байна.

Тухайн аймагт хичнээн компани үйл ажиллагаа явуулдаг тухай мэдээллийг лицензийн өгөгдлийн сангаас харах боломжтой бөгөөд ОУИТБС-д хамрагдсан компаниудын талаарх мэдээллийг Хүснэгт 18-д танилцуулав. Олон аймгийн нутаг дэвсгэрт олон тооны компаниуд лиценз эзэмшдэг нь ОУИТБС-ыг орон нутгийн түвшинд хийх боломж, шаардлага байгааг илтгэнэ. Сүүлийн хоёр хүснэгтээс харахад хүрээний мэдээллийг компани тус бүрээр гаргасан нь хангалтгүй, харин төсөл тус бүрээр мэдээлэл гаргах шаардлагатайг илтгэж байна. Төсөл тус бүрээр компаниуд мэдээллээ гаргасан тохиолдолд л орон нутгийн иргэдэд хамгийн чухал шаардлагатай мэдээллийн нэг болох тухайн ордоос орон нутгийн засаг захиргаанд төлөгдөж буй төлбөрийг харах боломжтой болох юм.

Дүгнэвэл, лицензийн болон ОУИТБС-ын өгөгдлийн санг нэгтгэснээр олборлох үйл ажиллагааны нөлөөнд өртөгч нутгийн иргэдийг тэдэнд хэрэгцээтэй нэмэлт мэдээллээр хангах боломжийг нээж өгч байна. Гэхдээ тухайн орон нутгийн иргэд, засаг захиргаанд өгч байгаа төлбөрийг тодорхой болгоход хэд хэдэн хүндрэл бэрхшээл байсаар байна. Тухайн компани цорын ганц лиценз, төсөл дээр ажилладаг бол бүх төлбөрийг тухайн үйл ажиллагаа явуулж буй төсөлтэй, улмаар төслийн орчны нутгийн иргэд, засаг захиргаатай холбох боломжтой. Гэвч олонхи компани олон газар нутагт үйл ажиллагаа явуулдаг тул төлбөрийг тухайн төсөлтэй холбох боломжгүй юм. Тиймээс ОУИТБС-ын зүгээс ОУИТБС-ын өгөгдлийг лицензийн мэдээлэлтэй холбох, улмаар тайлангийн маягтуудыг шинэчлэн өөрчилж, төсөл тус бүрээр тайлан гаргах шаардлагыг судлан үзэх шаардлагатай.

Ингэснээр тухайн төлбөр төрийн ямар байгууллага, орон нутгийн ямар төсөвт орж байгааг хянах зорилтыг биелүүлэх боломжтой юм.

Хүснэгт 18. Лиценз эзэмшиж буй компанийн тоо, аймгаар

Аймаг	ОУИТБС-д хамрагдсан, тухайн аймагт лиценз эзэмшиж буй компанийн тоо
Төв	106
Дорноговь	85
Өмнөговь	77
Сэлэнгэ	62
Дорнод	59
Хэнтий	56
Дундговь	55
Улаанбаатар	52
Баянхонгор	48
Сүхбаатар	46
Говь-Алтай	44
Булган	41
Дархан-Уул	27
Ховд	27
Баян-Өлгий	23
Увс	23
Хөвсгөл	21
Завхан	20
Архангай	18
Өвөрхангай	17
Говьсүмбэр	11
Орхон	4

5. Хавсралт 1: ОҮИТБС-ын өгөгдлийг нэгтгэж, ангилсан байдал ба өгөгдлийн дутагдалтай талууд



ОҮИТБС-ын өгөгдлийг чөлөөтэй хүлээн авах, дүн шинжилгээ хийх боломжийг нэмэгдүүлэх үүднээс олон жил цуглуулсан мэдээллийг бүгдийг нь өгөгдлийн нэгдсэн сан болгон хувиргах ажлыг энэ судалгааны эхний үр дүн болгон гүйцэтгэлээ. Өгөгдлийн нэгдсэн сан нь 2006-2011 оныг хамарсан ба анх компани, Засгийн газрын зүгээс гаргаж өгсөн тайлангаас гадна ОҮИТБС-ын нэгтгэлийн тайланд тусгагдсан зарим мэдээллийг оруулав. Дараа нь өгөгдлийн нэгдсэн санд орсон мэдээллийг хэлбэр, уялдаа холбоо талаас нь бүрэн цэгцэлсэн болно. Ерөнхийдөө өгөгдлийг цуглуулах, нэгтгэх, залруулах үйл ажиллагааг дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. ОУИТБС-ын өгөгдлийг ОУИТБС-ын Ажлын албанаас хүсэлт гарган хүлээн авсан болно.

Судалгааны багийн зүгээс ОУИТБС-ын Ажлын албанд хандан 2006-2011 оны ОУИТБС-ын өгөгдлийг гаргаж өгөх хүсэлт тавьсан юм. Бид дараах өгөгдлийн санг хүлээн авсан болно.

- 2006-2011 оны санхүүгийн жилийг хамруулан жил тутам Засгийн газраас гаргасан ОУИТБС-ын тайлан (MS Excel хэлбэрээр). Үүнд 2009 оны тайлан байгаагүй бөгөөд уг тайланг ОУИТБС-ын ажлын албанд дээрх хэлбэрээр ирүүлээгүй болно.
- 2006-2011 оны санхүүгийн жилийг хамруулан жил тутам компаниудын гаргасан ОУИТБС-ын тайлан, (MS Excel хэлбэрээр).
- 2006-2010 оны санхүүгийн жилийг хамруулан жил тутам аудитуруудын гаргасан ОУИТБС-ын нэгтгэлийн тайлан, (Adobe PDF ба MS Excel хэлбэрээр).

Уг төслийг эхлүүлэхэд бид ОУИТБС-ын өгөгдлийг хүснэгтэн хэлбэрээр авна гэж төсөөлж байсан ч зарим мэдээлэл ийм хэлбэрээр байхгүй байсан нь (тухайлбал, аудитуруудын тайлан, мөн 2006 оны нэгтгэлийн тайлан нь зөвхөн PDF хэлбэрээр) өгөгдлийг нэгтгэх, нэг хэлбэрт оруулах ажилд ихээхэн цаг, хүч зарахад хүргэсэн болно. Үүнтэй холбоотойгоор ОУИТБС-ын Ажлын алба нь ОУИТБС-ын төлбөрийн тухай өгөгдлүүдийг илүү системчилсэн бүтэцтэйгээр цуглуулж, хадгалах зөвлөмжийг гаргаж байна.

2. Өгөгдлийн нэгтгэл

Хүлээн авсан өгөгдлийн хувьд бид компани, Засгийн газраас анх гаргасан бүх тайланг нэгтгэсэн сан бий болгосон. Ингэснээр цаг хугацааны болон харьцуулсан төрөл бүрийн дүн шинжилгээ хийх боломжтой болох юм. Үүнд гол анхаарсан асуудал бол панел хэлбэртэй (ОУИТБС-ын Ажлын албанд хадгалж буй мэдээллийн хэлбэр; энэ нь хэдийгээр энгийн ч дүн шинжилгээ хийх, ялангуяа олон жилийн өөрчлөлт хувьслыг судлахад хүндрэлтэй хэлбэр) өгөгдлийг төлбөр тус бүрээр нь задлан бүртгэсэн хэлбэрт (ийм хэлбэртэй мэдээллийн хувьд төлбөр тус бүр өгөгдлийн санд тусдаа бичилт болно) оруулах явдал байв.

Энэ хөрвүүлэлтийг нэмж тайлбарлавал:

ОУИТБС-ын Ажлын албанд байгаа өгөгдөл, тухайн жил бүрээр (n-нийт компанийн тоо, m-нийт төлбөрийн хэмжээ):

	Компани 1	Компани 2	...	Компани n
Төлбөрийн нэр 1	Төлбөрийн хэмжээ 1,1	Төлбөрийн хэмжээ 1,2	...	Төлбөрийн хэмжээ 1,n
Төлбөрийн нэр 2	Төлбөрийн хэмжээ 2,1	Төлбөрийн хэмжээ 2,2	...	Төлбөрийн хэмжээ 2, n
...
Төлбөрийн нэр m	Төлбөрийн хэмжээ m,1	Төлбөрийн хэмжээ m,2		Төлбөрийн хэмжээ m,n

Бидний хөрвүүлсэн өгөгдөл нь 2006-2011 оныг хамрах ба дараах хэлбэртэй:

Компанийн нэр	Төлбарийн нэр, төрөл	Төлбөр
Компани 1	Төлбөрийн нэр 1	Төлбөрийн хэмжээ 1,1
Компани 1	Төлбөрийн нэр 2	Төлбөрийн хэмжээ 2,1
Компани 1
Компани 1	Төлбөрийн нэр m	Төлбөрийн хэмжээ m,1
Компани 2	Төлбөрийн нэр 1	Төлбөрийн хэмжээ 1,2
Компани 2	Төлбөрийн нэр 2	Төлбөрийн хэмжээ 2,2
Компани 2
Компани 2	Төлбөрийн нэр m	Төлбөрийн хэмжээ m,2
...
Компани n	Төлбөрийн нэр 1	Төлбөрийн хэмжээ 1,n
Компани n	Төлбөрийн нэр 2	Төлбөрийн хэмжээ 2,n
Компани n
Компани n	Төлбөрийн нэр m	Төлбөрийн хэмжээ m,n

ОУИТБС-ын PDF, MS Word хэлбэрт хадгалагдаж байсан аудитын тайлангийн өгөгдлийг MS Excel хэлбэрт оруулсан болно. Энэ ажил нь урьдчилж төлөвлөөгүй, нилээд хүчин чармайлт шаардсан ажил болсныг дурдах хэрэгтэй. Зарим аудит хийсэн байгууллагаас ажлынх нь өгөгдлийн хүснэгтүүдийг авах хүсэлт гаргасан ч оюуны өмчийн шалтгаанаар бидэнд гаргаж өгөөгүйг хэлэх нь зүйтэй.

3. Өгөгдлийн ангилал

Өгөгдлийг нэгтгэх дараагийн алхам бол төрөл бүрийн хэлбэрээр хялбар танилцуулах боломжийг хангах зорилгоор мэдээллийг хэд хэдэн ангилалд хуваасан болно. Тухайлбал, дараах 12 төрлийн ангиллаар өгөгдлийг танилцуулах боломжтой. Үүнд:

1) Мэдээллийн төрөл:

- Үндсэн мэдээлэл
- Сайн дураар гаргах мэдээлэл
- Бусад төрлийн мэдээлэл (тухайлбал, борлуулалтын хэмжээ, бүтээгдэхүүн, бусад мэдээлэл)
- Шийдвэрлэгдээгүй зөрүү (нэгтгэлийн тайлангийн)

2) Төлбөр орох төсөв:

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Хандив, дэмжлэг
- Бусад төлбөр ба өртөг (улсын болон орон нутгийн төсөвт алинд нь орсныг тодорхойлох боломжгүй төлбөр).

Энэ ангиллын хувьд ОУИТБС-ын тайлангуудаас шууд харах боломжгүй учир “Нэгдсэн төсвийн тухай хууль” зэргийг ашиглан бүх төлбөрийг тодорхой ангилалд хамруулсан болно.

3) Төлбөрийн төрөл:

- Татвар
- Төлбөр
- Хураамж, үйлчилгээний хөлс
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдэх төлбөр
- Төрийн байгууллагад олгох хандив, дэмжлэг
- Төрийн бус байгууллагад олгох хандив, дэмжлэг

Монгол Улсын татварын хууль, тогтоомжийн дагуу албан татвар, төлбөр, хураамжийг татвар гэж ангилдаг. Энд энэ ангиллыг ашигласан болно. Тухайлбал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь албан татвар бус, төлбөр гэх ангилалд хамрагдана.

4) Төлбөрийн нэр:

- Нэр бүхий 83 тусдаа төлбөрийн өгөгдлийг нэгтгэсэн. Үүнд жишээ нь:
- Автобензин, дизелийн түлшний татвар
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
- Гадаадын ажиллах хүчний ажлын байрны төлбөр
- Аймагт үзүүлсэн хандив, дэмжлэг г.м.

Зарим жилийн хувьд татварын нэр томъёо өөрчлөгдсөн, эсвэл янз бүрийн жилүүдэд өгөгдлийн санд ялгаатайгаар бүртгэсэн байсныг нэг мөр болгох ажлыг судалгааны багийн зүгээс гүйцэтгэсэн.

5) Компанийн нэр:

- 965 нэр бүхий компанийн өгөгдөл ОУИТБС-ын тайлангуудад 2006-2011 онд бүртгэгджээ.

6) Компанийн регистрийн дугаар:

- Компанийн улсын бүртгэлийн дугаарыг өгөгдлийн санд оруулсан байгаа. Энэ мэдээлэл бүрэн бус, зарим компани хэд хэдэн дугаараар бүртгэгдсэн (энэ нь бүртгэлийн дугаар олгох бодлого өөрчлөгдсөнтэй, мөн ОУИТБС-ын Ажлын албанд байгаа мэдээлэл, компани, Засгийн газрын тайланд орсон мэдээлэл зөрүүтэй, алдаатай байгаатай холбоотой), харин зарим компанийн хувьд мэдээлэл огт байхгүй байгаа зэрэг дутагдалтай тал ажиглагдав.

7) Тухайн компанийн харилцагч татварын албаны тухай мэдээлэл:

- Бүх компаниуд тодорхой татварын албатай харьцдаг ба энэ нь газар зүйн байрлал, компанийн үйл ажиллагааны хэмжээтэй гол төлөв холбоотой байдаг. Олон компанийн хувьд уг мэдээлэл огт байхгүй байна.

- 8) Компанийн хариуцлагын хэлбэр:
- Ихэнх компани хязгаарлагдмал хариуцлагатай, цөөн хэд нь хувьцаат компани байна. Энэ төрлийн мэдээлэл мөн л бүрэн бус байна.
- 9) Төлбөрийн хэмжээ:
- ОУИТБС-ын маягтын дагуу Засгийн газар болон компанийн гаргасан тайланд тусгагдсан төлбөрийн хэмжээ. Төлбөрийн ихэнх хэсэг нь нэгтгэл буюу аудитад тусгагдаагүй, учир нь нэгтгэлд хамруулах компанийн тоог төлбөрийн тодорхой босго хэмжээгээр хязгаарладаг.
- 10) Тайлагнагч тал:
- Засгийн газар
 - Компани
 - Аудитор; энэ тохиолдолд нэгтгэлийн дараа үлдсэн шийдвэрлэгдээгүй зөрүүг илэрхийлнэ.
- 11) Тайлангийн жил:
- Засгийн газар болон компанийн зүгээс ОУИТБС-ын тайлангийн мэдээлэл хамаарах санхүүгийн жил.
- 12) Салбар:
- Уул уурхай
 - Газрын тос.

4. Өгөгдлийг засварласан нь

ОУИТБС-ын Ажлын албанаас хүлээн авсан өгөгдөл нь учир дутагдалтай байсан тул хэд хэдэн зүйлийг засварлах шаардлагатай гэж бид үзсэн. Эдгээр дутагдлыг арилгах талаар ОУИТБС-ын Ажлын алба мэдээлэл цуглуулах, хадгалах явцдаа тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. **Мэдээлэл нь олон төрлийн үсгийн фонтоор бичигдсэн.** Өгөгдлийн сан нь Монгол хэл дээр байдаг. Монгол үсгийн төрөл бүрийн фонтыг компьютерт ашигладаг. Харахад Монгол үсгийн төрөл бүрийн фонтыг нь ялгаагүй байдаг ч мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийхэд кодчиллын ялгаа үүсдэг. Тухайлбал, хоёр өөр кодоор бичигдсэн ижилхэн үгийг компьютерийн программд өөр үг гэж тооцдог. Тиймээс бид бүх өгөгдлийг нэгдсэн Unicode Монгол үсгийн фонтыг уруу хөрвүүлсэн болно.
2. **Хэлбэр буюу формат ижил бус.** Зарим текстэн мэдээллийн мөр хоорондын зай нь өөр өөр, үгийн эхэнд болон хойно хоосон зайтай бичигдсэн. Энэ нь ижил мэдээллийг программаар таниулж дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулдаг. Ийм төрлийн алдааг засварлах шаардлагатай.
3. **Нэр томъёог өөр өөрөөр бичсэн ба түүнийг засварлах шаардлагатай.** Тухайлбал, нэг компанийн нэрийг хэдэн янзаар бичсэн байгаа нь өгөгдлийг шинжлэх явцад давхар тоолох зэрэг хүндрэл үүсгэдэг.

4. **Хагас дутуу мэдээлэл.** ОУИТБС-ын маягт өөрчлөгдөж ирсэнтэй холбоотойгоор өгөгдөл нь жилээс жилд бас шинэчлэгдэж тайлан гаргагч компанийн тоо нэмэгдсэн, мөн мэдээллийг цуглуулахдаа тогтсон нэг стандарт ашиглахгүй байгаагаас зарим жилийн тухайд бүрэн байгаа мэдээлэл өөр оны хувьд байхгүй байх тохиолдол элбэг байна. Тухайлбал, компанийн хариуцлагын хэлбэр, харилцдаг татварын алба зэрэг мэдээлэл зарим жилд байгаа ч, заримд нь огт байхгүй байна. Боломжтой бол бид ийм мэдээллийг цуглуулан нэгтгэж, зарим мэдээллийг байгаа оноос нь байхгүй жилд нь шилжүүлэх ажлыг хийсэн ч бүх компани, төлбөрийн хувьд ингэх боломжгүй байв.

Лицензийн өгөгдлийн сангийн тухай

ОУИТБС-ын тайланд компаниас Засгийн газарт өгсөн төлбөрийн тухай ихээхэн мэдээлэл хуримтлагдсан хэдий ч уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд хамгийн их өртсөн бүс нутгуудаар уг төлбөр хэрхэн хуваарилагдаж байгааг харах боломжгүй байгаа. Тиймээс ОУИТБС-ын өгөгдлийн санг бүрдүүлсний дараа бид уг өгөгдлийг лицензийн өгөгдлийн сантай (бусад жилийн лицензийн өгөгдөл байхгүй тул зөвхөн 2011 оны хувьд) нэгтгэж, улмаар тухайн бүс нутагт хэдий хэмжээний төлбөр өгдөг болохыг судлахыг зорьсон. Түүнчлэн бид ОУИТБС-ын өгөгдлийг Засгийн газрын төсөв, макро эдийн засгийн өөрчлөлт зэрэг бусад үзүүлэлтүүдтэй харьцуулж, иргэдийн мэдэх гэж хүсдэг зарим асуултад хариулт өгөх боломжийг судалж үзсэн юм. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд автсан нутгийн иргэд лицензийн болон ОУИТБС-ыг нэгтгэснээс танилцах боломжтой мэдээллийн талаар Хавсралт 2-т танилцуулсан болно.

6. Хавсралт 2: ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн сангаас уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй нутгийн иргэд ямар мэдээлэл авах боломжтой вэ?



Баянхонгор аймгийн Галуут сумын малчин Болд сүүлийн жилүүдэд нутагт нь болон уурхай ажиллаж байгааг ажиглаж байв. Яг ямар компани эдгээр уурхайг ажиллуулдаг, нийт хэдэн компани үйл ажиллагаа явуулдаг, ямар лиценз эзэмшдэг, засгийн газарт татвар, бусад хэлбэрээр хэдий хэмжээний төлбөр төлдөг талаар түүнд тодорхой мэдээлэл байхгүй. Орон нутгийн удирдлага нь уул уурхайн компаниудаас их хэмжээний санхүүгийн дэмжлэг авдаг тухай тэр сонссон ч найдвартай мэдээлэл байхгүй тул тэр мөнгийг хэрхэн зарцуулсан талаар Засаг даргаас асуухаас түвдэнэ. Уул уурхайн компаниуд ил тод, хариуцлагатай, ОУИТБС-ыг дэмждэг, лиценз нь олон нийтэд ил тод гэж хэлдэг ч ОУИТБС болон лицензийн мэдээллийн санд чухам ямар мэдээлэл байдаг талаар тэр мэдэхгүй. Суманд нь нутгийн иргэдийн эрх ашгийн үүднээс нөлөөлөх үйл ажиллагаа явуулдаг гэх иргэний хөдөлгөөнд Болд хандаж, ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг компаниуд биелүүлэх ёстой тухай шаардлага хүргүүлжээ. Иргэний хөдөлгөөний зохицуулагч түүнд ямар хариу өгөх боломжтой вэ?

Баянхонгор аймгийн Галуут суманд 10 компани 524.7 мянган га газарт үйл ажиллагаа явуулж 17 лиценз эзэмшиж байна.

Өнөөгийн байдлаар Галуут суманд 10 компани үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр компанийн жагсаалтыг Хүснэгт 19-д танилцуулав.

Дээрх компаниуд нийт 524.7 мянган га газрыг хамарсан 17 лиценз эзэмшиж буйг Хүснэгт 20-д танилцуулав. Эдгээр лицензийн ес нь ашиглалтын, үлдсэн нь хайгуулын лиценз байв. Талбайгаар нь авч үзвэл лицензтэй талбайн 56 хувь нь хайгуулын, харин үлдсэн 44 хувь нь ашиглалтын лицензэд хамаарахаар байна. Вэстэрн Ресорсис компани хайгуулын дөрөв, Эрчим Импэкс компани ашиглалтын нэг, хайгуулын хоёр лицензтэй байна.

Хүснэгт 19. Баянхонгор аймгийн Галуут суманд лиценз эзэмшиж буй компанийн жагсаалт

Компаниуд
Баялаг Орд
Монголболгаргео
Жамп Голд
Эрчим Импэкс
Гацуурт
Магнет Импорт
Рео
Ханшижир
Вэстэрн Ресорсис
Мондулаан Трейд

Хүснэгт 20. Галуут суманд олгогдсон лиценз, хамрах талбай

Компанийн нэр	Лицензийн төрөл, дугаар (XV-хайгуул, MV-ашиглалт)	Талбай (га)
Эрчим Импэкс	XV-012289	106,962.9
Эрчим Импэкс	XV-012287	76,706.3
Жамп Голд	MV-016653	73,034.7
Гацуурт	MV-011917	69,271.8
Ханшижир	XV-014932	55,802.9
Монголболгаргео	MV-000456	45,622.5
Ханшижир	XV-004371	28,623.3
Вэстэрн Ресорсис	XV-012057	15,951.6
Эрчим Импэкс	MV-007752	14,228.0
Баялаг Орд	MV-000222	7,986.4
Вэстэрн Ресорсис	XV-007804	7,478.8
Жамп Голд	MV-007741	7,317.1
Рео	MV-015643	5,858.1
Магнет Импорт	MV-012653	4,989.6
Вэстэрн Ресорсис	XV-008477	2,591.1
Вэстэрн Ресорсис	XV-006721	1,883.3
Мондулаан Трейд	MV-000125	377.9
Нийт талбай		524,686.1

Галуут суманд үйл ажиллагаа явуулж буй компаниуд 2011 онд нийт 4.243 тэрбум төгрөг Монгол Улсын Засгийн газарт төлсөн тухайгаа тайлагнажээ. Вэстэрн Ресорсис, Ханшижир гэх хоёр компани өөрсдөө ОУИТБС-ын тайлангаа гаргасан ч Засгийн газрын тайланд тэдний мэдээлэл тусаагүй байна. Харин Галуут суманд лицензтэй таван компани 2011 онд ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй ч Засгийн газрын тайланд тэдгээр компаниас хүлээн авсан төлбөрийн тухай мэдээлсэн байна. Энэ байдлаас үүдэн компаниуд, Засгийн газрын хооронд төлсөн болон хүлээн авсан төлбөрийн хэмжээ анхны тайлангаар 3.83 тэрбум төгрөгөөр зөрж байв.

Хүснэгт 21. 2011 оны ОУИТБС-ын хүрээнд компанийн болон Засгийн газрын тайланд хамрагдсан компаниудын төлбөрийн хэмжээ

Компанийн нэр	Засгийн газрын тайлан	Компанийн тайлан	Нийт	Зөрүү
Баялаг Орд	118,199.5	126,185.0	244,384.5	7,985.50
Вэстэрн Ресорсис		4,710.0	4,710.0	4,710.00
Гацуурт	1,980,118.7	2,063,827.3	4,043,946.0	83,708.60
Жамп Голд	1,615,544.2	1,742,969.2	3,358,513.4	127,425.00
Магнет Импорт	66,805.4		66,805.4	(66,805.40)
Монголболгаргео	409,649.0		409,649.0	(409,649.00)
Мондулаан Трейд	2,467,346.5		2,467,346.5	(2,467,346.50)
Рео	136,446.4		136,446.4	(136,446.40)
Ханшижир		305,712.0	305,712.0	305,712.00
Эрчим импэкс	227,069.7		227,069.7	(227,069.70)
Нийт	7,021,179.4	4,243,403.5	11,264,582.9	3,836,858.10

Энд Жамп Голд компанийн мэдээллийг сонирхоё. Тус компанийн төлсөн төлбөрийг Засгийн газар, компани хоёрын тайлагнаснаар Хүснэгт 22-т танилцуулав. Компани нийт 20 төрлийн төлбөр төлсөн ба Засгийн газрын хүлээн авсан, компанийн төлсөн гэж тайлагнасан хоёр дүнгийн хоорондын зөрүү 127.4 сая төгрөг байв. Хамгийн их хэмжээний зөрүүтэй дүн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл байв. Харин аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, байгаль орчны нөхөн сэргээх зардлын 50 хувьтай тэнцэх дэнчин, автомашины татвар зэрэг төлбөрийн хувьд зөрүү гараагүй байна.

Хүснэгт 22. Жамп Голд ХХК-ийн ОУИТБС-ын 2011 оны тайлан

Төлбөрийн нэр	Засгийн газрын тайлан	Компанийн тайлан	Зөрүү
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэлт төлбөр	936495.4	1088930	152435
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	267228.6	267228.6	0
Ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл	312745.2	187288.4	-125457
Ус, рашаан ашигласны төлбөр	22084.6	43369.2	21284.6
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	17917.6	36476.2	18558.6
Аймагт үзүүлсэн мөнгөн бус дэмжлэг	0	41500	41500
Аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	40000	0	-40000
Суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	0	24635.8	24635.8
Газрын төлбөр	9080.6	9268.6	188
Байгаль орчныг хамгаалах зардал	0	13800	13800
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	0	12392.2	12392.2
Төв, орон нутгийн засаг захиргаанд тодорхой хууль тогтоомжийн дагуу төлсөн үйлчилгээний хөлс	1172.2	9666	8493.8
Байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлын 50 хувьтай тэнцэх урьдчилгааг тусгай дансанд байршуулсан төлбөр	3000	3000	0
Гадаадын ажиллах хүчний ажлын байрны төлбөр (агентлаг)	5387.8	4829.8	-558
Гадаадын ажиллах хүчний үйлчилгээний хөлс	0	522	522
Суманд үзүүлсэн мөнгөн бус дэмжлэг	400	0	-400
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	32	32	0
Ажиллагсдыг дахин сургах, чадавхийг бэхжүүлэхэд зориулсан зардал	0	30	30
Нэмэгдсэн өртгийн албан татвар (татварын алба)	0.2		-0.2
Нийт	1615544	1742969	127425

Галуут суманд үйл ажиллагаа явуулж буй компаниудын лиценз, төлбөрийн мэдээллийг ийнхүү товч танилцуулснаас үзэхэд ОУИТБС-ын болон тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг нэгтгэх замаар тухайн газар нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын тухай ихээхэн мэдээллээр нутгийн иргэдийг хангах боломжтой байна. Гэхдээ хэд хэдэн саад тотгор байгаагийн улмаас тодорхой төлбөрийг яг тухайн орон нутгийн засаг захиргаанд төлөгдсөн эсэхийг мэдэх нөхцөл бүрдэхгүй байгааг өмнө нь дурьдсан. Тиймээс ОУИТБС-ын болон лицензийн өгөгдлийн сангаас орон нутгийн засаг захиргаатай холбоотой ямар мэдээллийг авах боломжтой болох талаар доорх хүснэгтэд жагсааж танилцуулав.

Хүснэгт 23. ОУИТБС болон лицензийн өгөгдлийн санд уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж буй нутгийн иргэдэд хамаарах мэдээллийн жагсаалт

Мэдээллийн төрөл	ОУИТБС-ын өгөгдөл	Лицензийн өгөгдөл	Тэмдэглэл
Компанийн нэр	Тийм	Тийм	ОУИТБС болон лицензийн өгөгдлийн санд аль алинд нь энэ төрлийн мэдээлэл байгаа тул хоёр санг холбоход компанийн нэрийг ашигласан болно.
Компанийн бүртгэгдсэн эзэд	Үгүй	Тийм	
Компанийн жинхэнэ эзэд	Үгүй	Үгүй	
Компанийн бүртгэлийн дугаар	Дутуу	Тийм	ОУИТБС-ын тайланд тусгагдсан олон жилийн өгөгдөл нь бүрэн бус, зарим жилийн хувьд огт байхгүй, зарим тохиолдолд компаниуд бүртгэлийн хэд хэдэн дугаартай байгаа.
Эзэмшиж буй лиценз	Үгүй	Тийм	ОУИТБС-ын 2011 оны нэгтгэлийн тайланд компанийн эзэмшиж буй лицензийн судалгаа хийгдсэн ч иж бүрэн бус, сайн нягтлагдаагүй мэдээлэл юм.
Лицензийн төрөл	Үгүй	Тийм	Лиценз нь ашиглалтын, хайгуулын аль нь болохыг лицензийн өгөгдлийн санд танилцуулсан байгаа.
Нутагт нь лиценз эзэмшиж буй аймаг сум	Үгүй	Тийм	
Үйл ажиллагаа явуулж буй аймаг сум	Үгүй	Тийм	
Лицензтэй талбайн хэмжээ	Үгүй	Тийм	
Олборлож буй ашигт малтмалын төрөл	Дутуу	Дутуу	Лицензийн өгөгдлийн санд ашиглалтын лицензийн хувьд олборлох ашигт малтмалын төрлийг тусгадаг.
Төлбөрийн төрөл	Тийм	Үгүй	Лицензийн өгөгдлийн сангаас төлбөл зохих лицензийн төлбөрийн хэмжээг л тооцсон байдаг.
Орон нутгийн засаг захиргаанд төлсөн төлбөр	Дутуу	Үгүй	ОУИТБС-ын өгөгдлөөс ямар төлбөр орон нутагт орсон болохыг зарим жилийн хувьд мэдэх боломжгүй; энэ мэдээллийг тухайн жилийн төсвийн хууль тогтоомжоос гарган авах боломжтой.
Төлбөрийн хэмжээ	Тийм	Үгүй	
Тухайн орон нутгийн засаг захиргаанд төлсөн төлбөр	Дутуу	Үгүй	Нэмэлт мэдээлэл дээр үндэслэн тухайн төлбөр орон нутгийн төсөвт орсон эсэхийг ОУИТБС-ын өгөгдлөөс харах боломжтой ч компани олон аймаг, сумдад лицензтэй бол яг аль орон нутагт, ямар төлбөр орсон болохыг хянах боломжгүй.